



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА



Энэхүү модулийг БШУЯ, ЖАЙКА хамтран хэрэгжүүлж буй “Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулав.

БАГШЛАХУЙН ХӨГЖИЛ: ТӨСӨЛТ АЖЛЫН МОДУЛЬ

ЕБС-ийн багш нарт зориулав.

Улаанбаатар хот

2013

БАГШЛАХУЙН ХӨГЖИЛ

ТӨСӨЛТ АЖЛЫН МОДУЛЬ

ЕБС-ийн багш нарт зориулав.

Улаанбаатар
2013 он

БОЛОВСРУУЛСАН БАГ:

Ахлагч:

Ц.Наранцэцэг

МУБИС-ийн Багшийн Сургуулийн багш

Гишүүд:

Б.Булган

МУБИС-ийн Багшийн Сургуулийн багш

Б.Нарантуяа

“Гурван эрдэнэ” дээд сургуулийн багш

Л.Намуунтуяа

Булган аймгийн БСГ-ын мэргэжилтэн

Г.Норжмаа

Нийслэлийн СБД-ийн 45 дугаар бүрэн дунд сургуулийн багш

Д.Нарантуяа

Сэлэнгэ аймгийн 4 дүгээр бүрэн дунд сургуулийн багш

Наканиши Рейко

Нийслэлийн БГД-ийн “Монгени” бүрэн дунд сургуулийн багш

ЭКСПЕРТИЙН БАГ:

Аðëàã:

Чодингийн Ганцэцэг

БШУЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Ноокоогийн Оюунцэцэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн Сургуулийн багш

Бадамжавын Золзаяа

МУБИС-ийн Компьютер, Мэдээллийн Технологийн Сургуулийн ахлах багш

Шагдарсүрэнгийн Сайнбилэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерийн Сургуулийн багш

Цэвэгжавын Пагмасүрэн

МУБИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн багш

РЕДАКЦИЙН БАГ:

Жамцийн Нарантуяа

БШУЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Оросоогийн Оюунтунгалаг

Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтын дэд захирал

Бямбаагийн Цасанчимэг

Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтын монгол хэл, уран зохиолын арга зүйч

ЗӨВЛӨХ БАГ:

Иший Тэцүя

Төслийн менежер

Сүзүки Саяака

Сургалт, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Такахата Хироши

Токио Гакугэй их сургуулийн профессор

Камата Масахиро

Ō èèĭ Ààéóāýé èõ ñóððóóéèéí профессор

Фүкүчи Аkitэрү

Токио Гакугэй их сургуулийн профессор

Мацүра Шюү

Токио Гакугэй их сургуулийн профессор

Бадамсамбуугийн

Төслийн мэргэжилтэн

Хишигбаяр

ГАРЧИГ

УДИРТГАЛ.....	5
ҮНДСЭН БҮЛЭГ	
1. “Төсөлт ажил” багийн сургалтын хэрэгцээ, зорилго, агуулга.....	6-8
2. Агуулгыг хэрэгжүүлэх арга зүй.....	9
3. Арга зүйн төлөвлөлт.....	10
3.1. “Төсөлт ажил” багийн сургалтын нэг дэх өдөр.....	11-30
3.2. “Төсөлт ажил” багийн сургалтын хоёр дахь өдөр.....	31-53
3.3. “Төсөлт ажил” багийн сургалтын гурав дахь өдөр.....	54-68
ХАВСРАЛТ	
1. Модулиар сургалт явуулах хөтөлбөр.....	69
2. Ажиглагчид хичээлд үнэлгээ хийх хуудас-Б2.....	70
ЛАВЛАГААНЫ МАТЕРИАЛ.....	71

УДИРТГАЛ

Монгол Улсын БШУЯам, Японы “ЖАЙКА”-тай хамтарч 2006-2009 онд хэрэгжүүлсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих аргазүйн хөгжил” төслийн хүрээнд “Төсөлт ажил” багийнхан, ЕБС-д шөй үр өдөөл айсан ч ашиглах ном гарын авлага огт байхгүй байсан Ө нө өд аапын аргазүйг өй ай дөй ё ай äөд æө үүй äүүд өөёäóóðëäì боловсруулж, туршаад “Төсөлт ажлын аргазүй” зөвлөмжүүдийг багш нарын хүртээл болгосон нь багш нарыг эрэлтэд нийцсэн бүтээл болж чадсан юм. Ингээд модуль сургалтад оролцогчдод тодорхой болгох үүднээс зөвлөмж тус бүрийн агуулга, онцлогийг дурьдвал,

“Төсөлт ажлын аргазүй” зөвлөмж-1 (áî ëî ãñðî ëûí ò;âø èí : ááâà)

- Бага боловсролын багш нарт төсөлт ажлын талаар $\hat{y} \hat{y} \hat{a} \hat{i} \hat{y} \hat{e} \hat{o} \hat{y} \hat{a} \hat{o} \hat{i} \hat{e} \hat{e} \hat{a} \hat{e} \hat{o}$ өгөх, $\hat{a} \hat{e} \hat{i} \hat{o} \hat{y} \hat{i} \hat{y} \hat{o} \hat{a} \hat{a} \hat{r} \hat{o} \hat{y} \hat{d} \hat{y} \hat{a} \hat{e} \hat{y} \hat{y} \hat{l} \hat{e} \hat{x} \hat{e} \hat{d}$ нь гарын авлага болгох зорилготой таван хэсэг, гурван хавсралттай бичигдсэн.
- Хавсралтад төсөлт ажил (integrated studies), төсөлт хичээл (project lesson), амьдрах ухааны хичээлүүдийн ялгааг монголын болоод японы бага сургуулийн сургалтын жишээн дээр үзүүлэхийг зорьсон.
- Бага боловсролын түвшинд, монголын хөрсөнд амжилттай буулгаж туршиж шинэ аргазүй босгосон Нийслэлийн СБДүүргийн 45, БЗДүүргийн 97, БГДүүргийн “Сэтгэмж” цогцолбор сургуулиудын багш нарын туршилтыг бодит жишээ болгон оруулсан.

“Төсөлт ажлын аргазүй” зөвлөмж-2 (ái ěi āĩđī ēũ í ò;âø èí : суурь)

- Төслийн хүрээнд БХАНийгэмлэгээс авсан судалгаагаар “Төсөлт ажил”-ын хэрэгжилт ЕБС-ийн соооü âí ëí âñðî ëüí ò¿âø инд нэлээд тааруу гарсан нь ð°ñ°èò àæëîг суурь боловсролын түвшинд хэрэгжүүлэх аргазүйг âí ëí âñðîëëàх үндэс болсон юм. (Үүнийг зөвлөмжийн III бүлгээс дэлгэрүүлж уншиж болно.) Тиймээс төслийн хоёрдахь жилээс “Төсөлт ажил” багийнхны боловсруулсан аргазүйгээр УБ хотын 3 сургуулиас гадна Сэлэнгэ, Дорнод аймгийн 6 сургуулийн 15 багш бага, суурь боловсролын түвшинд амжилттай туршсан ба бодит жишээнүүдийг уг зөвлөмждөө оруулж өгсөн.
- Суурь боловсролын түвшинд зохион байгуулах төсөлт ажил нь нэлээд өвөрмөц онцлогтой байдаг ба хэрэгжүүлэх арга хэлбэр нь ч бага боловсролынхоос ялгаатай байдгийг IY, Y бүлэгт тодорхой оруулсан.
- Төсөлт ажилд хичээлийн судалгаа хийх онцлог болоод зөвлөмж 1-д дурьдагдаад өнгөрсөн “Төсөлт хичээл”-ийн талаар дэлгэрэнгүй оруулж жишээнүүдийг хавсралт-1 (Японы бодит жишээ), хавсралт-2 (Монголын бодит жишээ) –т оруулсан.

“Төсөлт ажлын аргазүй” зөвлөмж-3 (áî ëî ãñðî ëûí òçâø ëí : ááãà, сүүр)

- Зөвлөмж-3 нь үндсэндээ төсөлт ажлыг бага, суурь боловсролын түвшинд туршиж төсөлт ажлыг монголын ” хөрсөнд буулгаж, нутагшуулж” чадсан багш нарынхаа ажлыг нэлээд дэгэрэнгүй (15хх), агуулга, сэдвийн хүрээ, боловсролын түвшингээр нь төрөлжүүлж оруулсан.
- Төсөлт ажлын төлөвлөлтийг хэрхэн хийх вэ? гэдэг асуудал явцын дунд тулгамдаж ирсэн тул хэрхэн төлөвлөж болох хувилбаруудыг зөвлөмжийн

- Өнөө үед мартагдах шахам байгаа монгол ёс заншил, өв уламжлал, зөв амьдрах ухаан, зөв төлөвшил хандлага болон дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа тогтвортой хөгжлийн асуудлуудыг төсөлт ажилтай хэрхэн уялдуулж болох тухайд олон сайн туршилт ажлуудыг оруулсан.

[illegible]

Төслийн II шат “Багшлахуйн аргазүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төсөл 2010-2013 онд хэрэгжиж байгаа бөгөөд төсөлт ажил багийнхан сургалтын модуль боловсруулж бүсийн сургагч багш нарыг бэлтгэж, хичээлд мониторинг хийж байна. Энэ ажилд УБ хотын СХДүүрэг, Завхан, Булган аймаг болон бүсэд сургагч багш, туршигч багш нар амжилттай сайн ажиллаж төсөлт ажлыг зохион байгуулах болоод төсөлт ажилд хичээлийн судалгаа хийх аргазүйг улам баяжуулан хөгжүүлж байна.

“Төсөлт ажил” багийн ахлагч Ц.Наранцэцэг

1. “ТӨСӨЛТ АЖИЛ” БАГИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ, ЗОРИЛГО, ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, АГУУЛГА

Хэрэгцээ:

Тогтвортой хөгжлийн төлөөх зорилгод нийцүүлэн, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх боловсролын чанарын шинэчлэл хийгдэж буй энэ цаг үед тогтвортой хөгжлийг авч явах иргэн төлөвшүүлэхэд хамгийн чухал нөлөөтэй “Төсөлт ажил”-ыг ЕБС-д жинхэнэ утгаар нь явуулах хэрэгцээ бий болж байна. Хэдийгээр манай сургууль, багш нарт өмнө хуримтлуулсан тодорхой туршлага, аргазүй байдаг ч орон нутгийн онцлог, орчин нөхцөл, анги бүлгийн ялгаа зэргийг тооцож, чанартай боловсруулан, түгээн дэлгэрүүлэх шаардлага урган гарч байна.

Зорилго:

Оролцогчдод төсөлт ажлыг мөн чанарынх нь дагуу зохион байгуулах аргазүй эзэмшүүлж, хэрэгжүүлэн туршихад нь дэмжлэг үзүүлэх

Хүлээгдэж буй үр дүн:

- Төсөлт ажлын онол, аргазүй, түүний мөн чанарын талаар цогц ойлголттой болж, туршин заах, хэрэглээ болгох арга барилд суралцана.
- Бага, суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг ялгарах онцлог, залгамж холбоотой заах, хичээлийн судалгаа хийх аргазүйд суралцана.
- Төсөлт ажлын онол, аргазүйн талаар мэдээлэл эрж хайх, цуглуулах, боловсруулах аргазүйд суралцана.
- Өөрийн орон нутаг, сургууль, анги, суралцагчдын онцлог байдалд тохируулан зааж, багшлахуйдаа гарч буй өөрчлөлт, туршлага, арга зүйгээ бусдад түгээн дэлгэрүүлэх сургалт явуулах тодорхой чадвартай болно.

Агуулга:


№	Сэдэв	Агуулга	Агуулгаа хүргэх хэлбэр	Цагийн багтаамж
1.	“ССДАЗХөгжил” төслийн хүрээнд Төсөлт ажил багийн хийсэн ажил “Бид эхний шатны төслийн 3 жилд”	• Монголын төсөлт ажлын арга зүйг боловсруулж, туршсан багийн танилцуулга • “Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж - 1,2,3 танилцуулга	лекц	90 мин
2.	Төсөлт ажлын арга зүй	• Бага боловсролын түвшний төсөлт ажлын арга зүй • суурь боловсролын түвшний төсөлт ажлын арга зүй • Төсөлт ажилд сурагчдын нас сэтгэхүйн онцлогийг харгалзах нь	лекц	60 мин
3.	Төсөлт ажлын сэдэв сонголт,	• Сэдэв сонгохын өмнөх удиртгал /оршил/ хичээл		

	төлөвлөлт	• Агуулга/сэдвийн хүрээ • Сэдвийн тор • Сэдэв сонголтод хийсэн судалгаа /монгол ба японы ЕБС-ийн төсөлт ажлын жишээн дээр/ • Судалгааны баг • Ангийн болон багийн ажлын төлөвлөлт	лекц дадлага	180 мин
4.	Төсөлт ажлын судалгаа	• Судалгаа, судалгааны аргууд • Мэдээллийн орчин • Мэдээлэл цуглуулах арга зам • Мэдээллийн боловсруулалт	лекц, дадлага	180 мин
5.	Төсөлт ажлын тайлан, үнэлгээ	• Явцын буюу завсрын тайлан • Эцсийн буюу нэгдсэн тайлан • Тайлангийн хэлбэрүүд, тус бүрийн онцлог • Үнэлгээ, үнэлгээний хэлбэрүүд • Сурагчдын чадварыг ахицаар үнэлэх нь	лекц, дадлага	330 мин
6.	Төсөлт ажлын онцлог	• Төсөлт ажил – интеграц хичээл • төсөлт ажил- хамтын ажиллагаа • төсөлт ажил ба тогтвортой хөгжлийн боловсрол • төсөлт ажил /integrated studies/ ба төсөлт хичээл /project lesson/	лекц	180 мин
7.	Төсөлт ажлын төлөвлөлт ба хичээлийн судалгаа	• төсөлт ажлын хөтөлбөр • төсөлт ажилд хичээлийн судалгаа хийх онцлог	лекц, дадлага	110 мин
Нийт цаг				1080 мин

2. АГУУЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГАЗҮЙ

- Энэхүү сургалтаа аль ч шатны сургалтад чухалд тооцогдож буй арга болох оролцогчдоор мэдлэг бүтээлгэх аргаар, өөрөөр хэлбэл оролцогчдын өмнөх мэдлэг, чадвар, туршлагад нь тулгуурлан явуулна. Ингэхдээ сургалтын лекц дадлагын цаг хугацааны дарааллыг “Дадлагын дараа лекц” маягаар төлөвлөж, мэдээллийг бэлнээр шууд өгөлгүйгээр, оролцогчид өөрсдөө дотоод нөөцөө илрүүлж байж мэдээллээ баяжуулж цэгцэлж авах боломжийг нээлттэй олгохоор төлөвлөсөн юм. Үүний зэрэгцээ санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, туршлага солилцох боломжийг хэлэлцүүлгүүдээр төлөвлөж оруулсан болно.
- Нөгөөтэйгүүр сургалтыг маань 1 бүхэл болгон хайрцаглаж байгаа үйл явц нь сургалтын эхэнд явуулах “Ярилцлага”, сүүлийн өдөр явуулах “Нэгдсэн хэлэлцүүлэг-3” бөгөөд сургалтын эхэнд төсөлт ажлын талаарх ерөнхий ойлголт, сургалтын дараах ойлголтуудыг харьцуулан харж сургалтын үр дүнгээ тооцон, дараагийн сургалтаа хэрхэн зохион байгуулахаа олж харна гэсэн үг. /Үүнийг “хүснэгт-1” -д бүдүүвчилж оруулав/
- “Дадлага-5” (завсрын тайлан хамгаалах) дээр оролцогч багш нараар төсөлт ажлын завсрын тайланг удирдуулж, ажиглуулж, “Хэлэлцүүлэг-2” дээр төсөлт ажлын хөтөлбөр, төлөвлөлт болон хичээлийн судалгааны онцлогоор хэлэлцүүлэг хийнэ. Ингэснээр төсөлт ажлын хичээлийн судалгааны онцлогийн талаар илүү биеэр мэдэрч суралцах болно.
- Сургалтаа явуулах бас 1 онцлог “Дадлага ажил-1” –ээс эхлэн оролцогчид төсөлт ажилд биечлэн оролцсоноор төсөлт ажлын мөн чанарыг өөрсдийн биеэр мэдэрч өөрөөр хэлбэл өөрсдөө сэдвээ сонгон, төлөвлөж судлаад, тайлагнах үйл ажиллагаанд оролцох юм. Ингэснээр төсөлт ажлын явцад тохиолддог саад бэрхшээл алдаа оноог өөрсдөө мэдэрч түүнийг хэрхэн даван туулах арга барилд суралцана гэсэн үг.
- Сургалтаа дараах арга зүйн төлөвлөлтийн дагуу явуулж төсөлт ажлын талаарх ойлголтын зөрүүг арилган нэгдсэн ойлголт өгч, оролцогч багш нарт, ямар ч хичээлдээ бүтээлчээр хувирган өөрийн болгон ашиглах бүтээлч аргуудад давхар суралцах боломжийг олгох болно.

3. АРГАЗҮЙН ТӨЛӨВЛӨЛТ



3.1. "ТӨСӨЛТ АЖИЛ" БАГИЙН СУРГАЛТЫН НЭГ ДЭХ ӨДӨР

МӨС ХАГАЛАХ МӨЧ

"Манай багийнхны намтар"

/15 мин/

Зорилго: Сургалтад оролцогчдыг бие биетэй нь танилцуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, хамтран суралцах

Дараах 5 асуултад багийн бүх гишүүд ярилцаж хариулаад, бусад багийнхандаа нэг нь илтгэж танилцуулна.

1. *Багийн гишүүдийн нэрсийг бичнэ үү.*
2. *Багийн гишүүд насаа нэмж, нийлбэрийг олно уу.*
3. *Багийн гишүүд ам бүлийн тоогоо нэмж, нийлбэрийг олно уу.*
4. *Танай багийнхны амралт, чөлөөт цагаараа хийх дуртай зүйл юу вэ?*
5. *Танай багийнхны урам зориг, сэтгэл санаа яг одоо ямар байна? Үүнийгээ өнгөөр илэрхийлнэ үү.*

Ашиглах материал

- **Эхлэл:** Оролцогчдыг хэд хэдэн баг болгон хуваасны дараа 5 асуулт өгч, багаар ажиллах зааврыг өгнө.
Явц: Баг дотроо гишүүн бүрийн хариултыг сонсож, том цаасан дээр нэгтгэж бичнэ. Хүн бүр хамт олны нэг гишүүн, багийн эд эс гэдгийг мэдрүүлнэ.
Төгсгөл: Баг бүрээс нэг гишүүн "Багийн намтар"-аа танилцуулах ба энэ үед сургагч багш намтрыг сонсонгоо самбарт нэгтгэнэ. Дараа нь хамгийн ахмад баг, залуу баг, эрч хүчтэй баг, оюуны баялгийг дээдэлдэг баг гэх мэтээр зарим нэг сонирхолтой мэдээлэл дээр тогтож ярилцана.
- Хамтын бүтээл гаргахад хүн бүрийн хувь нэмэр, санаа үнэ цэнэтэй болохыг хэлэлцэнэ.
- Суралцах гэдэг нь хүүхэд нэг нэгээрээ биш, багаараа, хамтдаа шийдэлд хүрэхийг хэлнэ. Төсөлт ажлын бусад хичээлээс ялгарах нэг онцлог нь хамтдаа шийдвэрлэх асуудлаа олж харж, асуудалд задлан шинжилгээ хийж, томьёолж, төлөвлөлт гаргаж, эрж хайж, судалж, хэлэлцэж асуудлыг шийдвэрлэдэг учраас багийн гишүүн бүрийн идэвхтэй оролцоо, шинэ санаа, баялаг сэтгэлгээ, ухаалаг зөвшилцөл шийдэл чухал байдаг гэдэг санаан дээр сайн тогтож, сайн эргэцүүлэн бодно.

Оролцогчдоос асуух 2-3 асуулт

- ~ Та яг одоо юу бодож байна вэ?
- ~ Амралт, чөлөөт цагаараа хийх дуртай зүйлээрээ ижил хүн байна уу? Хэрэв байвал та хоёрт өөр ижил төстэй зүйл байгаа болов уу?
- ~ Хүүхэд бүр ялгаатай юу? Яг ижил 2 хүүхэд байдаг уу?

/30 мин/

- Төсөлт ажлын онол, арга зүйн талаар тодорхой эх сурвалж /Зөвлөмж I, II, III/ - аас олж авсан мэдээллээ солилцох
- Өөр өөрсдийн сургууль дээр төсөлт ажил хэрхэн явагддаг талаар бусдадаа танилцуулах
- Танилцуулахдаа төсөлт ажлын “Сэдэв сонголт”, “Судалгаа”, “Тайлан”, “Үнэлгээ”-ий тухайд өөрийнхөө ойлголтыг 4 өнгийн цаасан дээр бичиж самбарын цаасан дээр наах

Ашиглах материал

- Төсөлт ажлыг тухайн аймаг, орон нутаг, сургууль бүр дээр өөр өөрийн онцлогтой явуулна. Юуг төсөлт ажлаар хийж, шийдвэрлэж болохыг сайн тунгааж үзнэ.
- Төсөлт ажлыг үр дүнтэй явуулахад нэгдмэл ойлголт, хамтын ажиллагаа чухал болохыг ярилцана.
- Төсөлт ажил явуулахын тулд бэлтгэл болгож, багш та ямар бэлтгэл хангах вэ?
 - Хүүхдээ (Хүүхэд судлал)
 - Хичээлээ (Хичээл судлал)
 - Өөрийгөө (БИ судлал)
 - Анги танхим, анги танхимаас гадаах орчныг (ОРЧИН судлал) г.м

Оролцогчдоос асуух асуулт

~ Яагаад, ямар учраас ингэж хариулав?

~ Тохиолдож буй бэрхшээлүүдийг дотор нь та өөрөө, сургууль, хамт олон, орон нутгийн байгууллага шийдвэрлэх боломжтойгоор нь 3 бүлэглэж үзэв үү?

~ Төсөлт ажил явуулах бэлтгэлийг хангаж, хэн юу юу хийж болох вэ?

“Төсөлт ажлын талаарх миний ойлголт, төсөлт ажил манай сургууль дээр”
тандах судалгаа

МЭДЭЭЛЭЛ 1

“Суралцагчдын суралцахуйг дэмжих аргазүйн хөгжил” төслийн хүрээнд ТӨСӨЛТ АЖИЛ багийн хийсэн ажил

- **“Бид эхний шатны төслийн 3 жилд”**
- **Төсөлт ажлын талаарх ерөнхий ойлголт**

/45 мин/

Үе шат	Хугацаа	Алхам агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн
Эхлэл хэсэг	5 мин	“Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн Төсөлт ажил багийн танилцуулга /бага, суурь боловсролын түвшинд/	Яригч ба сонсогч арга	ppt слайд, фото болон үйл ажиллагааны тайлан
Үндсэн хэсэг	30	-“Бид 3 жилд юу хийв?” Бага суурь боловсролын түвшинд хэрэгжүүлсэн төсөлт ажлын туршлага, сургамж -“Төсөлт ажлын аргазүй” зөвлөмж 1,2,3-ын онцлог, уялдаа холбоо, ашиглах талаар зааврын талаарх мэдээлэл	Гурван шаттай ярилцлагын арга	DVD 2, ppt слайд, ярилцах сэдэв сэдвийг баяжуулан уншиж судлах ном, гарын авлага, тайлан г.м
Төгсгөл хэсэг	10 мин	Төсөлт ажлын талаарх ерөнхий ойлголт	Том цаас дүүрэн бичих арга	Заавар бүхий ppt слайд, дотор нь жижиглэж задалсан дэд сэдвүүдийн дагуу бичих том цаас

Мэдээлэлд ашиглах материал

- Төсөлт ажил нь 2004-2005 оны хичээлийн жилд 1-10 ангид, 2005-2006 оны хичээлийн жилд 3-10 ангид, 2006-2007 оны хичээлийн жилд 4-9 ангид, 2007-2008 оны хичээлийн жилд 4-9 ангид, 2008-2009 оны хичээлийн жилд 5-9 ангид тус тус орж байсан ба 2009-2010 оны хичээлийн жилд 3-9 ангид, 2011-2012 оны хичээлийн жилээс 3-6 ангид орж байна.
- Төсөлт ажлын аргазүйг дараах бүрэлдэхүүнтэйгээр боловсруулсан болно.
 - 1) Японы Гакүгэй ИС /Асанума Шигэрү/
 - 2) МУБИС-ийн БС /Ц.Наранцэцэг, Б.Булган/
 - 3) МУБИС-ийн МСС /Ц.Оюун/
 - 4) Боловсролын хүрээлэн /Г.Содномваанчиг, Ш.Оюунцэцэг/
 - 5) ЕБС /Н.Наранцэцэг, Наканиши Рейко, Б.Гэрэл/
- Төсөлт ажлын аргазүйг туршиж заасан багш нар

Төслийн эхний жилд УБ хотын загвар 3 сургуулийн 6 багш (СБД-ийн 45-р сургуулийн багш Э.Мөнхтуяа, Г.Норжмаа, БГД-ийн “Сэтгэмж” цогцолбор сургуулийн

багш С.Лхагвацэнд, З.Нина, БЗД-ийн 97-р сургуулийн багш С.Алтантуяа, С.Дуламрагчаа нар төсөлт ажлыг бага боловсролын түвшинд туршсан.

Төслийн хоёр дахь жилд УБ хот, Сэлэнгэ, Дорнод аймгийн нийт 9 багш (БЗД-ийн 97-р сургуулийн багш Т. Эрдэнэчимэг, БГД-ийн “Сэтгэмж” цогцолбор сургуулийн багш До.Энхтуяа, СБД-ийн 45-р сургуулийн багш Ц.Оюунсанаа, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын сургуулийн багш Д.Ууганбаяр, Сэлэнгэ аймгийн төвийн нэгдүгээр сургуулийн багш В. Оюунбилэг, Сэлэнгэ аймгийн төвийн дөрөвдүгээр сургуулийн багш Д.Нарантуяа, Дорнод аймгийн “Хан-Уул” цогцолбор сургуулийн багш О. Дэлгэрцэцэг, Дорнод аймгийн тавдугаар сургуулийн багш С.Оюунчимэг, Дорнод аймгийн Матад сумын багш Ц.Энхмаа нар төсөлт ажлыг суурь боловсролын түвшинд тус тус амжилттай туршиж, өөр өөрийн гэсэн өвөрмөц арга барилаар хэрэгжүүлсэн болно.



БЗД-ийн 97-р сургууль дээр /2006 он/



МУБИС-ийн БС-ийн ББДССТөвд /2007 он/




МУБИС-ийн БС-ийн ББДССТөвд /2008 он/

“Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж-1 нь 2007 онд боловсруулагдсан ба бага боловсролын түвшинд төсөлт ажлыг хэрхэн зохион байгуулах талаар японы болон монголын бодит жишээн дээр, “Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж-2 нь 2008 онд боловсруулагдсан ба суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг хэрхэн зохион байгуулах талаар японы болон монголын бодит жишээн дээр тус тус тулгуурлан тайлбарласан юм. Мөн зөвлөмж – 2 т суурь боловсролын түвшний төсөлт ажлын арга хэлбэрүүд, төсөлт ажлын хичээлийн судалгааг хэрхэн хийх болоод төсөлт ажил, төсөлт хичээлийн ялгааг тодорхой жишээгээр оруулсан юм. Харин “Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж-3 нь 2009 онд боловсруулагдсан ба монголын нөхцөлд бага, суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг туршсан багш нарын туршлагыг оруулснаас гадна

төсөлт ажлын төлөвлөлтийг хэрхэн хийх аргачлалыг тодорхой оруулсан болно.
Жич: ([http://www.google.com/төсөлт ажил/төсөлт ажлын аргазүй](http://www.google.com/төсөлт%20ажил/төсөлт%20ажлын%20аргазүй)) хаягаар орж дээрх 3 зөвлөмжтэй тодорхой танилцана уу.

Төсөлт ажлын талаарх ерөнхий ойлголт

- Төсөлт ажил /integrated studies, projekt unterricht/ нь цогц, нэгдмэл, чөлөөт, ерөнхий шинжтэй.
 - Цогц - бүх хичээлийн агуулгыг хамарсан цогц шинжтэй байдаг. Төсөлт ажил нь бусад хичээлийн агуулгыг ашиглан, асуудлаа шийдвэрлэдэг.
 - Нэгдмэл - багш, сурагч, сургууль, байгууллага, иргэдийн нэгдмэл хамтын ажиллагааг шаарддаг.
 - Чөлөөт - хичээлийг зөвхөн танхимд бус, танхимаас гадуур, чөлөөтэй орчин нөхцөлд явуулдаг.
 - Ерөнхий - аливаа асуудлыг явцуу, тодорхой хүрээнд бус, ерөнхий, өргөн хүрээнд авч үздэг.
- Төсөлт ажлаар хүүхэд бие дааж асуудал дэвшүүлж чаддаг, бие даан суралцах, сэтгэн бодох чадвартай, дэвшүүлсэн асуудлаа олон хувилбараар шийдвэрлэж чаддаг болно. Энэ нь харилцааны чадвараар илэрнэ.



- Өөрөө өөртэйгээ харилцах чадвар нь эхний 2 чадвар бий болсон цагт бүтээгдэх хэдий ч хамгийн чухал суурь нь болно. Бусадтай харилцах харилцаа нь ангийн нөхөд, дээд, доод, зэргэлдээ ангийн хүүхдүүд, эцэг эх, үйлчилгээний хүмүүс, олон нийт, орон нутгийн удирдлагатай харилцахаас эхэлнэ. Хүүхдийн харилцааны чадвар хэдийчинээ сайн байна, төдийчинээ сайн төлөвшинө. Харин харилцааны чадваргүй хүн нийгэмд амьдрах аргагүй, нийгмээсээ тасарна.
- Хүний өдөр тутмын амьдрал байгаль, нийгэмтэй шууд холбоотой байдаг учраас байгаль, нийгмийн орчинтой зөв харилцах явдал их чухал юм. Ингэсэн цагт өөрийгөө таних, нээх, илэрхийлэх чадвар аяндаа бий болно.
- Хүүхдээс ирээдүйн амьдралынх нь зам мөр, хэн болох, юу хийх талаар асууж, амьдралын зорилгыг нь мэдэж болно. Өөрөө өөрийнхөө зорилгыг тодорхойлоход өөртэйгээ харилцах чадвар чухал нөлөөтэй.
- Төсөлт ажлыг бага ангид явуулах сургалтын сэтгэл зүйн үндэс нь “Хүүхдэд их мэдээлэл өгч, түүнийг эзэмшүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэхийн оронд хүүхэд юу сурах чадвартай, юунд сонирхолтой вэ? гэдгээс эхэлбэл зохино” гэж Жан Жак Руссогийн хэлсэн үгтэй дүйнэ. Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалд сурах үйл ажиллагааг багшаас удирдах, сурагчид өөрсдөө жолоодох гэж ангилна.
- Судалгааны бүтээлүүдэд сурах үйл ажиллагаагаа сурагчид өөрсдөө жолоодох нь түүний зохион байгуулалт, бие даасан ажиллагаанд нөлөөлдөг тухай бичсэн байдаг. Ийм учраас сурагчдад сурах хэрэгцээ буюу хүсэл тэмүүллийг бий

болгох төлөвшүүлэх хамгийн энгийн арга нь сонирхлыг нь татах явдал юм.

Сонирхлыг нь төсөлт ажил болон байгалийн сонирхолтой үзэгдлүүд, амьдралын туршлага дээр нь тулгуурлан үүсгэж болно.

- Сурч-танин мэдэх хүсэл тэмүүлэл нь өөрөө аяндаа үүсдэггүй. Харин түүнийг бий болгоход багшийн удирдлага шийдвэрлэх үүрэгтэй.
- Сурагчдад сурах хүсэл /сэдэл/ тэмүүлэл төлөвшүүлэхэд тэдний танин мэдэхүйн онцлогийг харгалзах
- Аливаа үйл ажиллагаа нь уг үйл ажиллагааны гол зүйлийг зорилго руу нь түлхэж өгөх хүчин зүйл буюу үйл ажиллагааны өдөөгчтэй байдгийг чухалчлах
- Төсөлт ажлаар хүүхдийг хөгжүүлэх нэг хүчин зүйл нь суралцагч бүрээ хэн болохыг нь таньж мэдэх, өөрөөр хэлбэл манай ардын сурган хүмүүжүүлэх ухааны “савыг үзэж сургах” онолоор “савыг” нь мэдэж байх учиртай.
- Төсөлт ажлыг явуулахад анхаарах нэг зүйл бол бага ангийн сурагчид сурах үйл ажиллагаагаа жолоодох чадвар шаардлагын хэмжээнд төлөвшөөгүй байх тул сурах ба сургах үйл ажиллагааг удирдахад багшийн удирдлага голлож багш төвтэй байх ба үйл ажиллагааны талаас сурагчдын үйл ажиллагаа голлох нь мэдээж. Өөрөөр хэлбэл, бага ангийн сургалт нь дадлага ба дадлага- онол голлосон хэлбэрүүд байх
- Хүний хөгжлийн судалгаа нь хүүхдийн амьдралын эхний есөн жилд өсөлтийг нь тодорхойлж болох дэс дараалсан өөрчлөлтийг дамждаг болохыг $\bar{o}\bar{i}\ \bar{a}\bar{i}\ \bar{d}\bar{o}\bar{i}\ \bar{e}\bar{e}\bar{n}\bar{i}\ \bar{i}$ байдаг. Эдгээр өөрчлөлт нь бие бялдар, сэтгэл хөдлөл, нийгмийн болон танин мэдэхүйн хөгжлийн хүрээнд явагддаг.
- Насзүйн өөрчлөлт нь багш нарын ажиллах хүрээг тогтооно.
8-13 насны хүүхдийн уураг тархинд тусгалын /мять/ төвүүд хэлбэржин хөгжиж байх тул энэ насны хүүхэд мэдээллийг хүлээн авч тогтоох уужим бололцоотой байна. Гэвч мэдээллийг “нийлэгжүүлэн” /синтезлэх/ оюун дүгнэлт хийх сэтгэхүй тэр болгон хөгжиж амжаагүй байдаг байна.

Хүснэгт-2

		<i>өгнө.</i>			
<i>Алхам 3</i>	<i>5 мин</i>	<i>Сонирхсон сэдвээ сонгоход нь чиглүүлнэ.</i>	<i>Онцлог тус бүрийг харгалзан өөрсдийн сонирхсон сэдвээ сонгоно.</i>	<i>3-2-1 арга</i>	<i>Заавар бүхий ppt слайд, боломжит сэдвийн хувилбарууд</i>

Дадлага ажилд ашиглах материал

- **Эхлэл:** Багшаас ямар санаа гарах бол? гэсэн таамаглалаа урьдчилан, жагсаан бичнэ. Юуг сурч, танин мэдэх гэж байгаагаа урьдчилан харах чадварыг хөгжүүлнэ.

Явц: Өөрт байсан, өмнө нь мэддэг байсан зүйлээ ч сэргээн санах боломжтой. Тухайн сэдвийн талаар өөрийн мэдэх зүйлээ товч бичнэ.

Төгсгөл: Тухайн сэдэв (“Төсөлт ажлын сэдэв сонголтын онцлог”)-тэй холбоотой агуулгын гол санааг тэмдэглэж авсны дараа түүнд үзүүэх хариу үйлдлээ бас бичнэ. Хүнд танин мэдэхүйн төвшингөөс гадна сэтгэл хөдлөлийн төвшин гэж байна. Өөрийн сэтгэл хөдлөлийг мэдрэх чадвар нь нэн чухал чадвар гэдгийг ярилцана.

Хүснэгт-3

СЭДЭВ СОНГОЛТ		
Хүүхдийн сонирхолд нийцсэн	Нийгэм болон хувь хүмүүст тулгамдсан	Хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон
Орон нутгийн онцлогийг харгалзсан	СЭДЭВ СОНГОЛТ	Сургуулийн төлөвлөгөөтэй уялдсан
Агуулга/сэдвийн хүрээний дагуу	Хүүхдийн ахуй амьдрал, үг хэллэгт ойр	Бусад хичээлүүд дээр давтагдахааргүй

- Анги ахих тусам төсөлт ажлын агуулга, хүрээ өргөжих учраас сонгож буй сэдэв ч үүнтэй уялдан, өөр өөр болно. Дотогшоо чиглэсэн сэдэв (өөр рүүгээ чиглэсэн), гадагшаа чиглэсэн сэдэв (бусад уруу, байгаль, нийгмийн орчин уруу чиглэсэн) гэж юу болохыг эргэцүүлэн бодно.
- Байгаль орчны тухай сэдэв сонговол төсөлт ажлын хүрээ өргөсдөгийг бодит жишээн дээр ярилцана.
Бүс нутгийн онцлогийг тусгасан, нутаг усаараа бахархах үзэл шингэсэн сэдэв их үнэ цэнэтэй байдаг.Тухайлбал, Сэлэнгэ аймгийн нэгэн сургуулийн YII ангийн сурагчид “Сэлэнгэ - Миний нутаг, миний бахархал” сэдвийн дор:
 - “Нутгийн цай”
 - “Талх”
 - “Загас”
 - “Үр тариа”
 - “Нарсан төгөлхөн”
 - “Эрүүл хоол хүнс” гэсэн дэд сэдвээр 6 баг болон, өргөн хүрээтэй судалгаа хийж, чухал хэд хэдэн асуудлыг шийдвэрлэсэн төсөлт ажлын сэдвийн торыг дараах жишээнээс харна уу.

- [illegible]

- 22

	Дэд сэдэв			Дэд сэдэв			Дэд сэдэв	
	Дэд сэдэв			Ерөнхий сэдэв			Дэд сэдэв	
	Дэд сэдэв			Дэд сэдэв			Дэд сэдэв	

Дадлага ажилд ашиглах материал

- Төсөлт ажлын сэдэв сонгохын өмнө хүн бүрээр сонирхож буй сэдвийг нь дэвшүүлж, дараа нь дэвшүүлсэн сэдэв бүр дээр санал хураан, тогтож ярилцаад, хамгийн олон хүн саналаа өгсөн сэдвийг төсөлт ажлын сэдэв болгон сонгоно. Тухайлбал, Нэгэн сургуулийн VII ангийн сурагчид 18 сэдэв дэвшүүлээд, 4 сэдэв сонгож, судалгааны 4 баг бүрдүүлэн, төсөлт ажил хийсэн байна.
 - “Миний эрүүл мэнд”
 - “Найз нөхөд”
 - “Мэдлэгийн далай”
 - “Өвөг дээдэс”
 - “Миний ахиц амжилт”
 - “Эрүүл хүнс”
 - “Утаа”
 - “Миний амьдрал ахуй



“Найз нөхөд”
 “Өвөг дээдэс”
 “Хүн чанар”
 “Бага нас”

- “Бие бялдрын хөгжил”
- “Эрх үүрэг”
- “Миний бусдад хандах хандлага”
- “Миний өөрийн эд хогшил”
- “Бага нас”
- Сэдвээс халихгүй байх, том сэдэв хүүхдэд үлдэц, үр дүн багатай байдаг, хүч тарамдаж ачаалалд оруулахгүй байхыг багш тооцно.
- Багш нар хүүхдийн сонгосон сэдвийн дагуу зэрэг судалгаа хийж, хүүхдэд дэмжлэг чиглүүлэг өгвөл үр дүнтэй. Иймээс багш нарыг ч хэд хэдэн баг болгож, хамтын судалгаа хийлгэж болно.
- Ном, сонин сэтгүүл, зөвлөмж, гарын авлага цуглуулж, урьдчилан бэлтгэж, анги танхимд мэдээллийн орчин бүрдүүлэх нь чухал. Бусдад үлгэр дуурайл болсон, сонин хачныг үзсэн харсан хүмүүсийг “Зочин”-оор урих тухай урьдчилан ярьж тохирно.
- Төсөлт ажлын явцад хийсэн, бүтээсэн ажил бүрийн тоогоор багана босгож, баганаа өндөрлөхийн тулд улам их зүйлийг хийх талаар хэлж өгнө.
Тасралтгүй үргэлжлэх амьдралд “асуудал”-ууд ар араасаа тулгамдаж байдаг. Тэдгээр тулгамдаж буй асуудал хүний амьдралд, хүнд өөрт нь нөлөөлж байна. Ийм асуудлыг хүүхдүүд олж хараад, томчуулд хүргэх гэж яарч, өөрийнхөө түвшинд шийдвэрлэхийг хичээдэг байна.

МЭДЭЭЛЭЛ 2

Төсөлт ажлыг Монголын нөхцөлд туршсан туршигч багш нарын туршлага, алдаа, оноо, түүнийг даван туулсан арга зам

/30 мин/

<i>Үе шат</i>	<i>Хугацаа</i>	<i>Алхам, агуулга</i>	<i>Арга</i>	<i>Хэрэглэгдэхүүн</i>
<i>Эхлэл хэсэг</i>	<i>.5 мин</i>	<i>Туршигч багш нар туршилтын үеийн алдаа, оноо</i>	<i>Фото хичээл</i>	<i>ppt слайд, үйл явцтай зургууд, DVD зурагт хуудас</i>
<i>Үндсэн хэсэг</i>	<i>20 мин</i>	<i>Туршигч багш нарын туршлага.</i>	<i>Биеэр мэдрүүлэх арга</i>	<i>ppt слайд, сэдвийн тор бичлэг</i>
<i>Төгсгөл хэсэг</i>	<i>5 мин</i>	<i>Даван туулах арга зам</i>	<i>Үзэл бодлын шугам</i>	<i>Багш нарын туршлага, тайлан Зөвлөмж-1,2,3</i>

МЭДЭЭЛЭЛ -3

“Төсөлт ажилд сэдэв сонголт чухал болох нь”



/20 мин/

Үе шат	Хугацаа	Алхам, агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн
Эхлэл хэсэг	5 мин	Төсөлт ажилд сэдэв сонголт чухал болох талаар ярилцаж үндсэн хэсэг рүү орох оршлыг хийх	Оролцогчид сэдвээ хэрхэн сонгосон талаар өөрсдийн саналаа бичсэн байх арга бичих	ppt слайд, “Төсөлт ажлын сэдэв сонголт” ханын цуврал мэдээлэл
Үндсэн хэсэг	10 мин	Сэдэв сонголтыг бага, суурь боловсролын түвшинд онцлог ялгаатай явуулах	Яригч ба сонсогч арга	ppt слайд, “Сэдэв сонголт” тэргүүлэгч асуудал бичих дэлгэцийн цаас
Төгсгөл хэсэг	5 мин	Мэдээллээ нэгтгэн дүгнэх	Том цаас дүүрэн бичих арга	Дэлгэцийн цаас, эсгий бал

Мэдээлэлд ашиглах материал

- Төсөлт ажилд хүүхдүүдийн сонирхол хэрэгцээг түлхүү анхаарахын хамт нийгмийн хөгжлийн шаардлагыг тооцон, сургууль болон хичээл нь амьдралд илүү нээлттэй болж байгааг давхар тооцно.
- Эхний цаг /сэдэв сонголт/ дээр багшийн үүрэг, мэдрэмж хамгийн чухал бөгөөд “багш-чиглүүлэгч” гэдгийг жинхэнэ утгаар нь харуулах учиртай.

“МЭДЭЭЛЭЛ-3”-т ашиглах ppt-ийн зарим зургийн тайлбар	
Улиралд нэг л сэдэв сонгох нь тохиромжтой ч ✓ Хүүхдийн онцлог /нас, хөгжил, анги/ ✓ Сонгосон сэдвийн агуулгын хүрээ ✓ Хүний нөөцийн байдал /багийн гишүүдийн чадвар/ ✓ Судалгаа явуулах орчны байдал /хот хөдөө/ зэргийг тооцож үзэх хэрэгтэй.	

	Сэдэв сонголтын үед багш сурагчдын дэвшүүлсэн сэдвүүдийг самбарт жагсаан бичиж агуулгаар нь нэгтгэж байгаа байдал
	Японд монголын сумочид өндөр амжилт гаргах болсонтой уялдаад япон хүүхдүүд монгол орныг ихэд сонирхон төсөлт ажлынхаа сэдэв болгон судалсан байна. Тэгээд монгол хүүхдүүдэд сонирхсон зүйлүүдээ асуусан захиа илгээсэн нь харагдаж байна. Тэд их энгийн мөртлөө сонирхолтой асуулт ирүүлсэн байв. /"Монгол хүүхдүүд харандаагаар бичдэг болов уу?", "Мориор хэр хол явж чадах вэ?", "Танайд олон давхар байшин байдаг уу?" г.м/ Ийнхүү бусад орныг сонирхон судлах нь төсөлт ажлын "Олон улсын ойлголт" гэсэн хүрээнд хамрагдана.
	Сэлэнгэ аймгийн төвийн 1-р сургуулийн 7^б ангийн сурагчид "Сэлэнгэ - миний нутаг, бидний бахархал" сэдвийг сонгож Сэлэнгэ аймгийнхаа брэнд бүтээгдэхүүнийг судалсан төсөлт ажил явуулсан юм. Зөвлөмж 3 60 дахь тал

	УБ хотын 45-р сургуулийн 8^б ангийн сурагчид “Монгол үндэсний хувцас” сэдвийг сонгосон нь өнөө үед түүх соёл, ёс заншлаа мартах шахаж байгаа залуу үеийнхэнд сургамжтай, сонирхолтой байлаа.
---	---

ДАДЛАГА- 2

- Сонгосон сэдвээр сэдвийн тор үүсгэх
- Сонирхлын бүлгээр судалгааны баг бүрдүүлэх
- Дэд сэдвүүдээр судлагдахуунаа гаргах
- Багийн төлөвлөлт хийх

/160 мин/

Алхам	Хугацаа	Багшийн үйл ажиллагаа	Оролцогчийн үүрэг	Арга	Хэрэглэг дэхүүн
Алхам 1	10 мин	Жижиг баг бүрдүүлээд, баг бүрт бэлэн сэдвийн тор өгч ажиглуулан, уг сэдвийн торонд нэмэлт баяжилт хийнэ	Өгсөн сэдвийн торонд нэмэлт баяжилт хийж, судалгааны тэргүүлэх болон дагалдах чиглэлээ тогтооно	Багцлах буюу утгын зураглал хийх	А-3 дээр буулгасан сэдвийн торууд А-2 цаас
Алхам 2	30 мин	Өөрсдийн сонгосон сэдвээр “Сэдвийн тор үүсгэх”-д нь чиглүүлнэ.	Өөрсдийн сонгосон сэдвээр “Сэдвийн тор” үүсгэнэ	Жижиг багийн гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх арга	Заавар бүхий ppt слайд, нэр хаяг бүхий ширээ, сандал, багийн ажил бичих том цаас

Алхам 3	20 мин	Багийн ажлын төлөвлөлт гаргахад хэрэгтэй зөвлөмж өгч, бодот жишээн дээр ярилцаад, төлөвлөлт гаргуулна.	Багаараа ярилцан, төлөвлөлт боловсруулаад, бусад багийнхандаа танилцуулж, тэдний тавьсан асуултанд хариулж, саналаа солилцоно	“Аквариум дахь ярилцлага”-ын арга	Багийн төлөвлөлтийн бодот жишээ 1, 2, 3 алдаа, оноог өгүүлсэн багш нарын тэмдэглэл
---------	--------	--	---	-----------------------------------	--

Дадлага ажилд ашиглах материал

- Төсөлт ажлын амин чухал зүйл нь оновчтой сэдэв сонголт, баялаг сэдвийн тор үүсгэх гэдгийг сайн ойлгож, сэдвийн тор үүсгэхдээ багш, сурагчид хамтарч бүтээхийн чухлыг ярилцана.
- Төсөлт ажил долоо хоногт танхимд 1 цаг ордог ч танхимаас гадуур хийх бүтээлч үйл ажиллагаа нь тасралтгүй үргэлжилнэ.
- Төсөлт ажилд төлөвлөлт чухал болохыг ярилцана.

Төсөлт ажлын төлөвлөлт нь 	Төсөлт ажлын төлөвлөлт нь үйл ажиллагааны нийлмэл нэгдэл, хамт олны төлөвлөлт юм.
Өөрийн төлөвлөлт гэж юу вэ? • Тухайн сэдвээр оролцогч өөрөөсөө “Би” юу хийж, чадах вэ? Гэсэн өөрийн асуултын хариултанд хийх өөрийн үйл ажиллагааны үйлийн төлөвлөлт юм. • <u>Өөрийн төлөвлөлт</u> • <u>Загвар 1</u> Багийн Сэдэв “Хөдөлгөөн” “Би” юу хийж, чадах вэ? “Зочин” урих	Багийн төлөвлөлт багийн гүшүүн тус бүрийн өөрийн төлөвлөлтөөс эхэлнэ.

“Хөдөлгөөн” багийн гишүүн
Батэрдэнийн зочин урих төлөвлөлт 1

Хаана	Хэзэ э	Хугацаа	Ямар зорилго ор	Хэни йг урих вэ?	Бэлдэ х зүйл
Чандман а – эрдэнэ сургууль 208 тоот	2012. 11.13	11.10- 11.20 10 минут	Ангийнха ндаа “Хөдөлгөө н ямар ач тустай вэ? Гэдгийг л яриулах	Биеий н тамир ын багш Болд	“Зочин урих”Т өлөвлө лт гаргах
				6.01	6.02

Төлөвлөлт 2 “Зочин” урихад юу бэлдэх вэ?


“Зочин” угтаж авах	Зочинг танилцуула х	Ангийн хаана байрлах	Яаж ярилцах /юунаас эхлэх/	“Талархал илэрхий лэх
Би өөрөө Б/О 1 Юу гэж хэлж угтах вэ? -Таныг ирнэ гэдэгт. -Бидний урилгыг...	Зочингоо яаж танилцуулах вэ? Б/О 2 “Миний урилгаар “Цагаа баригч” “Ирсэнд баярлалаа” гэх мэт сонголтоос тууз зүүлгэх, малгай өмсгөх,	Сурагчийг сонсох Б/О 3 “Ангийн төвд талбай” засах	Ярилцах хуудас /хөтөлбөр”/- ийг үзэх Б/О 3 Зөвлөх	Сурагчидтай зөвлөх Б/О 4 Хувилбар санал болгох -Дуу дуулах -Фото зураг өгөх -Гэр бүлд нь талархал илгээх -Албан газарт

Багийн
гишүүний
өөрийн
төлөвлөлтий
н эхний
хэсгийн үйл
ажиллагааны
төлөвлөлт
юм.

Багшийн төлөвлөлт

№	Хийх ажил	Хугацаа	Анхаар ах зүйл	Сайжру улах арга зам	Өгсөн санаа
1.					
2.					
3.					

Сурагчид
сэдвээ
сонгож
төлөвлөлтөө
хийж
эхэлмэгц
Ангийн багш
өөрийн
төлөвлөлтөө

Төлөвлөлт - Өөрчлөлт - Үйл явц 	зэрэг гаргана. Төлөвлөлт нь суралцагч, баг, багшийн хамтын ажиллагааны тасралтгүй өөрчлөлт бүтээлч үйл явц юм.
--	---

- Хүүхэд өөрийгөө нээж, таньж мэдсэний дараа улам хүчтэй болдог учраас хүүхэд бүрийн хувь нэмэр, оролцоо чухал гэдгийг ойлгуулна.
- Төсөлт ажлын судалгааны явцад хүүхдүүд хүрээлэн буй орчноо дахин дахин өөрөөр харж, мэдэрдэг болно.
- Төсөлт ажлын үр дүн бусад хичээлийн арга зүйд ч сайнаар нөлөөлдөг.

Мэдээлэл цуглуулах ажлаа төлөвлөхдөө дараах зүйлүүдийг анхаараарай.

- Мэдээлэл цуглуулах, түүнд яаж боловсруулалт хийх тухай аргачлал
 - Мэдээлэл гэж юу вэ? мэдээллийн төрөл
 - Мэдээллийг яаж цуглуулж эрж хайх вэ?
 - Мэдээллээ яаж боловсруулан, төрөлжүүлэх вэ? түүнийгээ хэрхэн тайлбарлах вэ?
 - Мэдээллийн орчин бүрдүүлэн, мэдээлэл солилцоо чухал болох нь
- **Ì ýäýýéýë öóæóóëàð çëë ýâð í ü àí ðäàä- àà õî , ðäî ã- ì ýäýýéýë öóæóóëàð äýñýí 2 çä ø àðàë.**
Àíðäàä- ìýäýýéýë: Õýäýæýä-äýýñ çëë àæëëäàäàí ü öóðàë ñàí àë ðçñýëðëëä í ü ñî í ñî õ, òýäýí òýë ýðëëðàæì ýäýýéýë àààð
Õî,ðäîã- ìýäýýéýë: Çàñæëí æçàð, Õðëëí áàëæóóëäàä, æì ì àí è, èðäýí èé í èéä èéí áàëæóóëäàäàñ æðæàñàí ñàððëñðëë õîí, áàðëè ò, ñààææà, ñîí èí , ì ýäýýëëëéí ì àðàðëàë àø èæàð
- **Ì ýäýýëëëéí îð-ëí :**
 - Õýäýæýë äýä ñàëðóóä
 - Í î ì , æðüí ààëàä
 - Õððëæñí ýð, ñî í èí ü ðàë-ëëäàð
 - CD, DVD
 - Ñóðæëëüí ì àðàðëàëóóä
 - Çóðàæð ðóóàñ

- Òǎǎǎǎǎǎ, ñí í èí , òóòòòǎǎ

• **Ì yáyúyèyè yǎǎ òǎǎǎ**

- Òòǎǎǎí ñyáyàòyè òí éǎí í òí é ì yáyúyèèèǎǎǎǎǎǎǎǎǎǎǎǎ òǎǎǎǎ òáyǎǎǎǎí ìǎǎí yáyǎ.
- Í í í ãǎǎí ãǎǎǎǎǎǎ òí ò èǎǎǎǎǎǎǎǎǎǎǎǎ ò.
- Òí éǎí ãǎí èòí é ò í òí çóðǎǎǎí èí í çóðǎǎǎ òóóǎǎí ãǎǎǎǎǎǎǎǎǎǎǎǎ ò.
- Òyǎyè ì yáyúyèèèéí òyǎyǎǎyǎyǎ ãǎǎǎǎí áǎǎǎǎ ò òóǎǎǎǎǎǎǎǎ
- TV, сонин, бичлэгтэй хуурцаг сонсох, цуглуулах
- Óǎǎǎǎǎǎ, yǎǎǎǎǎǎǎ çí òéí í áǎǎǎǎǎǎǎǎ
- Мэдээллүүдийг цуглуулан товъёоглон цэгцлэх

• **Ì yáyúyèyè òóǎǎǎǎǎǎ í èéòéyǎǎǎǎǎǎ**


- Ìǎí òǎǎǎǎǎǎǎǎí yǎǎǎǎǎǎǎǎ
- Áǎǎǎǎǎí yǎǎǎǎǎǎǎǎ
- Ìǎǎǎǎǎ
- Áǎǎǎǎ ò áǎǎǎǎǎǎ ò éí ãǎǎǎǎǎ
- Ìǎí òòí í ñí ù ãǎǎǎǎǎ

Áyýðò ãǎǎǎǎ í ù þ óǎǎǎǎǎǎǎǎǎǎǎǎ ãyǎǎǎǎǎǎǎǎǎǎ ò ãǎǎǎǎǎǎǎǎ ò° ò° òéí í í òéí ãǎí é.

Àǎǎǎǎ

Áǎǎǎǎ ò òóǎǎǎǎǎǎǎǎ ì ãǎ òí òéí ì ãǎí é ãǎǎ.

- Àǎǎǎǎǎ áǎ ò° òéí áǎǎǎǎǎǎǎǎǎǎǎǎ ãǎǎí ò.
- Í yýèòóyè, òǎǎèòòǎé, òǎǎǎ òǎǎèòòǎé ãǎǎǎǎ òyǎyǎǎí y.
- Àǎǎǎǎ ãǎǎǎǎǎǎǎǎ ì yǎyǎǎǎǎǎ òǎǎ éí ã ñǎǎí áí èí ãǎǎǎǎǎǎǎǎǎǎǎǎ ãǎǎ



Óǎǎǎǎǎ òyǎyǎ

Àǎǎǎǎǎ ãǎǎ òǎí ççñǎǎí òǎǎǎǎǎ ì yáyúyèyè ãǎǎǎǎí çí òéǎǎ , ì yáyúyèyè °ǎ°í òǎí ççñǎǎí í óóòú ã òǎǎǎǎǎǎ, çí yí áí ãèòí é ì yáyúyèyè °ǎ°í òéǎǎǎí ãǎí òçñyèò, ãǎǎǎǎǎ í òí èòí í òǎí ççñò yì ãð ãǎ èǎǎé áǎǎǎ áy ãy ì yò áð°í òéé ì yáyúyèyè ãǎǎǎí ò.

Àǎǎǎǎǎ í òí èòí ã-ǎí í òǎǎǎǎǎ ì yáyúyèyè

Àǎǎǎǎǎí í í òéí ãǎ éí ãçǎǎǎǎǎǎǎǎǎǎ á°ǎ°ǎ yéǎí ãyǎ°° òéí ñóǎǎǎǎí ù ì ãǎ ÷óðǎé ã- òí éǎí ãǎí èòí é ì yáyúyèèèǎí èǎǎǎǎ í í òéí ãǎǎǎǎǎǎǎí ãǎǎǎǎǎǎǎǎǎǎǎǎ òóóéí ò.

Áǎǎǎ òí yáyú

Ì yáyúyèyè áí èí ãǎǎǎǎǎǎǎ ò ãǎǎǎǎǎǎǎǎ ñòǎòèñòèè, òí í í áí èí í ÷ǎí ãðúí ãy ì yò í èí í òǎǎí ì yáyú áǎǎǎ òú ãí òóóǎǎ

Í yéǎyú:

Алхам 4	20 мин	Судалгаанд ямар, ямар аргуудыг хэрэглэх вэ? Судалгаанд боловсруулалт хэрхэн хийх вэ? г.м асуулт тавина	Асуултын дагуу туршлагаа хуваалцахад бэлтгэн, сонирхсон асуултаа сонгож. Хостойгоо хамтран хариулж бичнэ	Сонгож ярилцах, тэмдэглэл хөтлөх арга	Заавар бүхий ppt слайд, томоор бичсэн асуултууд, төсөлт ажлын судалгааны тулгуур дохио \зургаар\
------------	--------	--	---	--	---

Дадлага ажилд ашиглах материал

- Тэргүүлэгч асуудлыг тодорхойлох \3-2-1 арга\

Эхлэл: Олон асуудлыг дотор нь шүүн тунгааж үзээд, чухал гэж үзсэн 3-ыг жагсаан бичнэ. Тэдгээр 3 асуудлыг дахин нягталж үзэн, дотор нь чухал ба чухал бусаар нь ялгана.

Явц: Чухал 3 асуудал дотроосоо нэн чухал гэж үзсэн 2 асуудлыг дугуйлна. Дараа нь бүр чухал гэж үзсэн 2 асуудлыг дотор нь эрэмбэлэн тэмдэглэнэ.

Төгсгөл: Бүр чухал гэж үзсэн 2 асуудлыг дотор нь дахин нарийвчилж авч үзэн, хамгаас чухал гэж 1 асуудлыг үлдээгээд, нөгөө асуудлаас ялгахын тулд тодотгон тэмдэглэнэ. Ингээд хамгаас чухал, тэргүүлэгч 1 асуудлыг авч үлдэнэ.

- Судалгааг 3 аргаар хийдэг.
 - Уулзалт ярилцлагын арга
 - Уншиж тэмдэглэл хөтлөн судлах арга
 - Туршилт хийх арга
- Уулзалт ярилцлагын аргын төлөвлөлт
Уулзалт ярилцлагын удирдагчийн бэлтгэл:
 - Өөрийн танилцуулгыг товч бэлдэх,
 - Хэнтэй хамтрах вэ? хэн туслах вэ?
 - Ярилцлагыг хэрхэн удирдан хөтлөх вэ?
 - Ажил үүргийн хуваарийг хэн гаргах вэ?
 - Судалгааны нөхцөл байдлыг хэрхэн судлан тооцох вэ? гэх мэт

Уулзалт ярилцлагын төлөвлөлт

№	Ярилцах хүн	Ярилцлагын зорилго	Хэзээ, хаана уулзалт болох	Ярилцлагын үргэлжлэх хугацаа	Ярилцлагын асуултыг бэлтгэх, тэмдэглэх
1					
2					
3					
4					

Ярилцлагын асуултыг бэлтгэх

Анхны хөтлөх асуулт

Цаашид чиглүүлэх асуулт

Тодруулах асуулт

Хариултаас үлбаалсан асуулт

- Баримт цуглуулах арга:

Зорилго: Судлаач тухайн сэдэвтэй холбоотой он цаг хугацааг тодорхой тэмдэглэх

Сэдэв	Он тоолол	Бичиж тэмдэглэсэн үг, хэлсэн хүний нэр
-	-	-
-	-	-

- ì ýäúýëýë ýðæðàéð, цуглуулахдаа:

1. Одоагй пүяүдөгө өй ёай һий ёй үяүүеёёәәәәһөөһәй оодөй оәуәәһһй еәй уяүд
2. Ном гарын авлагаас уншиж цуглуулах
3. Холбогдолтой фото зураг болон зурагт хуудсыг цуглуулах /зурган мэдээлэл/
4. Ыәәёёй үяүүеёёей дүдүйәиёүд әәдһәй аадөй ò ööәööөәәд /TV, һий ей ,
әә÷ёүәюё öööдөөәә/
5. Öөçәәөд, үдөөөөәәә çй дөй й аәәәдөөәәд
6. Сонингийн хайчилбараас бүтсэн сонин г.м


- Сонингийн хайчилбараас бүтсэн сонин. Энэ нь сонгосон сэдвийнхээ тухай сонингоос олж уншин, түүгээрээ цуглуулга хийж дахин хайчилбар сонин үүсгэж, бусдадаа өгөх, мэдээлэл худалдах, солилцох
- Мэдээлэл цуглуулах явцад, өөрт тохиолдож буй бэрхшээлийг цувуулан бичнэ. Тухайлбал,
 - Хугацаа тулсан
 - Төлөвлөлтөө дутуу хийсэн
 - Мэдээллээ цэгцэлж амжаагүй байсан
 - Шивж хийх байсан гэх мэт оролцогч бүр бичнэ.

Ямар бэрхшээл тохиолдсон, яаж даван туулсан бэ?

Тохиолдсон бэрхшээл	Бэрхшээлийг даван туулсан нь	Шийдэж чадаагүй нь
-	-	-
-	-	-
-	-	-

- Бэрхшээлээс яаж гарах вэ?
 - Өөртөө жагсаалт гаргах
 - Хостойгоо жагсаалтаа нэгтгэх
 - Багаараа нэгтгэн чухлыг сонгох
 - Гарах арга замыг шийдвэрлэх

“ДАДЛАГА-3”-т ашиглах ppt-ийн зарим зургийн тайлбар




Бага ангид судалгаа хийх аргыг тулгуур дохио ашиглан ойлгуулах ба зураг дээр судалгааны явцад үзэх харах, унших үйл ажиллагааг түлхүү хийснээ тэмдэглэж үзүүлжээ.

- Хийж бүтээх
- Харах
- Үнэрлэх
- Мэдээллээ судлах явж
- Сонсох

Зөвлөмж 1 31 дэх тал

	
	<i>Ном ашиглан бариа заслын талаарх мэдээллийг боловсруулж байгаа нь</i> <i>Зөвлөмж 1 35 дахь тал</i>
	<i>Сүү цагаан идээг хэрхэн боловсруулах талаар судалсан багийнхан өөрсдийн гараар хийсэн цагаан идээгээ дэлгэн тавьжээ.</i> <i>Зөвлөмж 1 34 дэх тал</i>

	<i>Хүнсний ногоогоор төрөл бүрийн салат хийж байгаа байдал</i>
	<i>Зөвлөмж 1 33 дахь тал</i>
	<i>Сэлэнгэ аймгийн брэнд бүтээгдэхүүн болох утсан загасыг хэрхэн хийх аргатай танилцаад өөрсдийн гараар утсан загасаа бусдадаа амсуулахаар авчирсан байдал</i>
	<i>Зөвлөмж 3 68 дахь тал</i>

МЭДЭЭЛЭЛ -4

Төсөлт ажлын хичээлийн судалгаа

/30 мин/

Төсөлт ажлын хичээлийн судалгаа /төсөлт ажлын бэлтгэл судалгаа, төсөлт ажлыг ажиглах, тэмдэглэл хөтлөх, хэлэлцүүлэг/ хийх онцлог

Үе шат	Хугацаа	Алхам агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн
Эхлэл хэсэг	10 мин	Хичээлийн судалгаа ба төсөлт ажил	Мэдээлэл солилцох арга	Хичээлийн судалгааны талаар сургалтын эхний өдөр олж авсан мэдлэгт нь тулгуурлах
Үндсэн хэсэг	15 мин	Төсөлт ажилд хичээлийн судалгаа хийх онцлог		DVD 2, ppt слайд, ярилцах сэдэв

				сэдвийг баяжуулан уншиж судлах ном, гарын авлага, тайлан г.м
Төгсгөл хэсэг	5 мин	Стандарт, хөтөлбөртэй хичээлд хичээлийн судалгаа хийх, төсөлт ажилд хичээлийн судалгаа хийх ялгааг харьцуулж дүгнэх		ppt слайд,

Мэдээлэлд ашиглах материал

Төсөлт ажлын үе шат бүрийн онцлогоос шалтгаалж, хичээлийн судалгаа ч өөрийн гэсэн онцлогтой байна. Төсөлт ажлын явцыг дараах үе шатанд хуваана. Үүнд:

Сэдэв сонгох үе	Төлөвлөх үе	Судалгааны үе	Явцын тайлангийн үе	Судалгааны үе	Эцсийн тайлангийн үе
-----------------	-------------	---------------	---------------------	---------------	----------------------

Үе шат бүрийн онцлогийг явцын тайлангийн үеийн хичээлийн судалгаан дээр авч үзье. Явцын тайлан буюу төсөлт ажлын судалгааны явц байдлаа тайлагнах хичээл дээр хүүхдүүдийн бүтээлч үйл ажиллагаа давамгайлна. Харин төсөлт ажлын эхэн үед багшийн үйл ажиллагаа голлодог учраас хичээлийн судалгаа ч багш руу илүү чиглэсэн байна. Харин судалгааны ид үеэс хүүхдүүдийн үйл ажиллагаа, идэвх оролцоо голлох учраас энэ үеийн хичээлийн судалгаанд:

- Хүүхдүүд юу юу хийв?
- Яаж өөрчлөгдөв? гэдгийг чухалчилна.

Явцын тайлангийн үед судалгааны багууд хийсэн ажлаа тайлагнадаг ч хүүхдүүдийн идэвх оролцоо харилцан адилгүй байдаг. Иймд тэднийг:

- Илтгэсэн хүүхдүүд
- Илтгээгүй хүүхдүүд гэж хоёр бүлэгт хувааж болно. Хоёр бүлгийн хүүхдүүдийг ч дотор нь ялгаж болно. Илтгэсэн хүүхдүүдийг:
- Өөртөө итгэлтэй
- Өөртөө итгэх итгэл нь дунд зэрэг
- Өөртөө итгэлгүй гэх мэтээр ангилаад, төсөлт ажлын явцад яаж өөрчлөгдөж байгааг нь ажиглаж, тэмдэглэл хөтөлнө.

Илтгэх чадварын хувьд:

- Мэдээллийг сонгосон байдал
- Мэдээлэлд боловсруулалт хийж ажилласан байдал
- Мэдээллийг өөрийн болгосон байдал
- Мэдээллийг бусдад дамжуулах, илтгэх байдал
- Мэдээллийг илтгэхдээ ашигласан цахим болон бусад хэрэглэгдэхүүний сонголт зэрэг дээр тогтож, ажиглаж судална.

Илтгээгүй хүүхдүүдийг дотор нь:

- Алтан дундаж хүүхэд
- Хүний нүдэнд огт тусдаггүй хүүхэд
- Харилцах бэрхшээлтэй хүүхэд
- Сурах бэрхшээлтэй хүүхэд гэх мэтээр багш өөрийн өмнөх ажиглалт, туршлага дээр тулгуурлан ангилж судална.
- Хамгийн гол нь хичээлийн судалгааны үед тэднийг сайн ажиглана. Ажиглалтын арга нь ажиглах, ажигласан зүйлээ тэмдэглэх гэсэн 2 үе шаттай ба ажиглалтын тэмдэглэл хөтлөх олон арга байдаг. Ажиглагч багш нарын хувьд сургагч багшийн өгсөн зааварчилгааны дагуу ажиглалт хийхдээ тэмдэглэл хөтлөх дараах аргуудыг оновчтой хэрэглэхийг сануулна. Үүнд:
 - Үгчлэн тэмдэглэл хөтлөх арга
 - Үгэн тэмдэглэл хөтлөх арга
 - Хугацаат тэмдэглэл хөтлөх арга
 - Сэргээн санаж, тэмдэглэл хөтлөх арга
 - Үйл үгээр тэмдэглэл хөтлөх арга
 - Төхиолдлын тоог олж, тэмдэглэл хөтлөх арга
 - Зураасаар тэмдэглэл хөтлөх арга
 - Схем, диаграмм, зураглалаар тэмдэглэл хөтлөх арга
 - TV үзэх аргаар тэмдэглэл хөтлөх арга
 - Цаг хугацааны хүснэгтээр тэмдэглэл хөтлөх арга гэх мэт.

Багш дээрх арга тус бүрийн мөн чанарыг сайтар ойлгон, сонголт хийж, суралцагчдыг төсөлт ажлын явцын тайлангийн үед ажиглангаа тэмдэглэл хөтөлснөөр үнэлгээг бодитой болгох боломж нээгдэнэ. Ерөөс тэмдэглэл нь тухайн суралцагчийн байр байдал, чадвар хандлага, хүч чармайлт, ахиц амжилт зэргийн илэрхийлэл болсон “өвөрмөц цуглуулга” юм.

Тухайлбал, хугацаат тэмдэглэл хөтлөх арга гэдэг нь урьдчилан тогтоосон хугацааны дараа хийгдэж буй үйлдэл, үйл ажиллагааг ажиглаж, тэмдэглэл хөтлөхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, урьдчилан тогтоосон хугацааны эцэст тухайн хүүхэд юу хийж байгааг зургийн аппаратаар хальсанд буулгаж байгаа мэтээр дүрсэлж тэмдэглэнэ.

1 цагийн ажиглалт хийхдээ давтамжийн хугацааг 20 минут гэж үзвэл 20 минут тутамд хүүхдийн үйлдэл, үйл ажиллагааг ажиглаж, тэмдэглэл хөтөлнө. Тэгэхээр 1 цагийн ажиглалтын үед 4 удаагийн товч тэмдэглэл хөтлөх ба эхний тэмдэглэлийг ажиглалт эхлэнгүүт дараагийн тэмдэглэлийг 20 дахь минутад,

түүний дараагийн тэмдэглэлийг дараагийн 20 дахь минутад гэх мэтээр тогтоосон хугацаанд тэмдэглэнэ. Харин 20 минутын хооронд болж буй үйл явдлыг тэмдэглэхгүй./Сургалтын модулийн 38-р талаас харна уу/

Төсөлт ажлын явцын тайлангийн үед:

- Хүүхдийн идэвх оролцоог схем, диаграмм, зураглалаар тэмдэглэл хөтлөх аргаар,
- Хүүхдийн хандлага, харилцааг үгэн тэмдэглэл хөтлөх аргаар,
- Хүүхдийн үгийн сонголт, ярих, илтгэх чадварыг хугацаат тэмдэглэл хөтлөх аргыг сонгон, тэмдэглэл хөтөлж, хичээлийн судалгааны гол баримт болговол оновчтой. Үүний зорилго нь хүүхэд бүрийг төсөлт ажилд татан оролцуулах, эрэл хайлт судалгаа хийх арга зүйд сургах, тэдэнд тохирсон арга зүйг сонгоход чиглэгдэнэ.

Явцын тайлангийн үед:

- Судалгааны явцад хийж буй ажлаа ангидаа үргэлжлүүлэх
- Судалгааны үйл явцаа бусдад тайлагнах, илтгэх, хэлэлцүүлэх
- Судалгаатай холбоотой чиглүүлэг, зөвлөмжийг багш болон нөхдөөсөө авах
- Цаашдын судалгаандаа багш, нөхдийнхөө чиглүүлэг, зөвлөмжийг тусгах зэрэг бүтээлч үйл ажиллагааг төлөвлөнө.

Хичээлийн судалгаа хийхдээ:

Агуулгын хувьд

Багш хүүхдүүдийн сонгосон сэдвээр зэрэг судалгаа хийнэ. Хүүхдүүдийн цуглуулсан мэдээлэл нь сонгосон сэдвээсээ халих, давхцах, гол зүйлээ гол бусаас ялгахгүй байх зэрэг тал ажиглагддаг. Судалгааг улам үр дүнтэй болгохын тулд багш уншиж судлах номын нэр, хуудсыг, мөн уулзаж ярилцах хүмүүсийн нэр, хаягийг тодорхой хэлж өгнө. Багшийн үнэ цэнэтэй зөвлөмж, оновчтой чиглүүлэг чухал учраас хичээлийн судалгаа хийхдээ сонгосон сэдэвтэй холбоотой хэлж буй багшийн үг, өгүүлбэр, хийж буй үйл хөдөлгөөн бүрийг нарийн ажиглана.

Арга зүйн хувьд

Багш уг хичээлийг өвөрмөц арга зүйгээр хөтлөх учраас багшийн арга зүйг чухалчлан үзнэ. Өөрөөр хэлбэл, төсөлт ажлыг багшийн бүтээлч арга зүйд суурилсан, шинэ арга зүйг туршихын төлөө бүтээгдсэн хичээл гэж ойлгож болно. Ийм учраас энэ хичээлийн үед багшийн хэрэглэж буй арга зүйг нэг бүрчлэн ажиглаж, оновчтой эсэхийг судална.

Төсөлт ажлын явцын тайлангийн үед:

- ~ Би хэн бэ? арга
- ~ Яригч ба сонсогч арга
- ~ Санал бодлоо бүлэглэн хуваалцах арга
- ~ Том цаас дүүрэн бичих арга
- ~ Өөрийн тэмдэглэл хөтлөх арга
- ~ Санал нийлж байна, санал нийлэхгүй байна арга
- ~ Тэргүүлэгч асуудлыг тодорхойлох 3-2-1 арга

зэрэг аргуудыг хослуулан хэрэглэх боломжтой.

Төсөлт ажлыг явуулахдаа тухайн насны хүүхдийн онцлогийг харгалзан, тэдний сонирхлыг төрүүлэх, танин мэдэх үйлийн аргад суралцах, харилцан ярилцах, хэлэлцэх, асуултаар хөтлөх зэргээр суралцагчийн оролцоог нэмэгдүүлэх олон хэлбэрийг сонгоно.

Сургалтын орчин ба хэрэглэгдэхүүний хувьд

Төсөлт ажлын явцын тайлангийн үед хүүхдүүдийн янз бүрийн эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, бусад хэрэглэгдэхүүнээр өвөрмөц орчинг бүрдүүлнэ. Баг бүрийн бүрдүүлсэн орчин ил тод, нээлттэй байх учраас аль баг төсөлт ажлаар юу юу цуглуулж, мэдээллийн орчин бүрдүүлэв? бусад багийн өвөрмөц орчноос юу юуг тусгах вэ? гэдгээ өөрсдөө олж харах боломжтой юм. Хүүхдүүд ном, гарын авлага, интернэтээс олж авсан мэдээлэлд боловсруулалт хийснээ олон аргаар илэрхийлж тавихаас гадна биет, бодит хэрэглэгдэхүүн, хүмүүстэй уулзсан ярилцлагын тэмдэглэл, зураг хөрөг гэх мэтээр баялаг хэрэглэгдэхүүнээ тавина. Тэдгээр нь сонгосон сэдэвтэйгээ хэр уялдаатай байгааг, яаж цэгцэлж боловсруулсныг, төсөлт ажлын орчинг хэрхэн бүрдүүлснийг чухалчлан авч үзнэ.

Мэдлэг эзэмшилтийн хувьд

Сурагчид сурах үйл ажиллагаагаа жолоодох чадвар хангалттай хэмжээнд төлөвшөөгүй учраас төсөлт ажлын үед багш чиглүүлэг чухал ч үйл ажиллагааны талаас сурагчдын бүтээлч үйл ажиллагаа голлоно.

Орхондөөн өрөө, өөрчлөлт нь бие бялдар, сэтгэл хөдлөл, нийгмийн болон танин мэдэхүйн хүрээнд явагддаг. Энэхүү өөрчлөлт нь багш нарын ажиллах хүрээг тогтооно.

8-13 насны хүүхдийн хувьд уураг тархинд тусгалын төвүүд хэлбэржин хөгжих тул энэ насны хүүхэд мэдээллийг хүлээн авч тогтоох өргөн боломжтой ч мэдээлэлд дүгнэлт хийх чадвар тэр болгон хөгжөөгүй байна. Мөн энэ насны хүүхдийн танин мэдэхүй нь бодитоос хийсвэрт, тодорхойгоос ерөнхийд шилжих чиглэлтэй байдаг онцлогийг нь орчин бүрдүүлэх болон арга зүй сонгохдоо тооцно. Энэ насны хүүхдийн оюун ухааны хөгжил нь бодит сэтгэхүйд тулгуурлан хөгждөг учир аливаа юмыг

шууд хуулбарлах, дуурайх гээд байдгийг анхаарч, үйл ажиллагааг нь чиглүүлнэ.

Төсөлт ажил нь суралцагчдын бие даан ажиллах чадвар, хамтын ажиллагаанд тулгуурлан бүтээлч сэтгэхүйг төлөвшүүлдэг, хүүхдүүд хоорондын эерэг харилцаа, идэвхтэй үйл ажиллагааг чухалчилдаг сургалт юм.

Төсөлт ажлыг хүүхдийн нас, сэтгэл зүйн хөгжлийн онцлог, бусад хүчин зүйлс авч үзэхгүйгээр үндэсний хүүхдүүдийн суралцах урам зоригийг бууруулах талтай байдаг. Иймд багш хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг ажиглаж, олж мэдэх шаардлагатай.

Төсөлт ажлын үед хамтын ойлголцоо, бодол, үйлдвэрлэл, хөгжлийн онцлог, бусад хүчин зүйлс авч үзэхгүйгээр үндэсний хүүхдүүдийн суралцах урам зоригийг бууруулах талтай байдаг. Иймд багш хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг ажиглаж, олж мэдэх шаардлагатай.

1. Төсөлт ажлын үед хамтын ойлголцоо, бодол, үйлдвэрлэл, хөгжлийн онцлог, бусад хүчин зүйлс авч үзэхгүйгээр үндэсний хүүхдүүдийн суралцах урам зоригийг бууруулах талтай байдаг. Иймд багш хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг ажиглаж, олж мэдэх шаардлагатай.
2. Төсөлт ажлын үед хамтын ойлголцоо, бодол, үйлдвэрлэл, хөгжлийн онцлог, бусад хүчин зүйлс авч үзэхгүйгээр үндэсний хүүхдүүдийн суралцах урам зоригийг бууруулах талтай байдаг. Иймд багш хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг ажиглаж, олж мэдэх шаардлагатай.
3. Төсөлт ажлын үед хамтын ойлголцоо, бодол, үйлдвэрлэл, хөгжлийн онцлог, бусад хүчин зүйлс авч үзэхгүйгээр үндэсний хүүхдүүдийн суралцах урам зоригийг бууруулах талтай байдаг. Иймд багш хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг ажиглаж, олж мэдэх шаардлагатай.

Үнэлгээний хувьд

Үнэлгээ гэдэг нь аливаа зүйлийн чанар, үнэ цэнийг тодорхойлох системтэй үйл явц юм. Суралцагчдын мэдлэг, чадварын талаар ойлголт авах зорилгоор үнэ цэнэтэй мэдээлэл цуглуулж, анализ хийж, хэлэлцэх бүтээлч үйл ажиллагаа юм.

Үнэлгээгээр олж авсан мэдээлэл нь суралцагчдын ил, далд буй нөөц боломж, том, жижиг алдаа дутагдлыг нээн илрүүлж, цаашдын арга замыг тодорхойлж өгдгөөрөө давуу талтай. Багш явцын тайлангийн үед хүүхдүүдийг урамшуулсан үг өгүүлбэрээр үнэлнэ. Судалгааны үед багшийн оновчтой үг өгүүлбэр маш чухал учраас судалгаа цааш үргэлжлэхэд чухал нөлөөтэй. Хамгийн гол нь хүүхэд юу мэдэж, юу хийж, чадаж байгааг ажиглаж үнэлнэ. Үнэлгээ нь байнгын ажиглалт, дүн шинжилгээ хийх хамтын үйл явц юм.

Төсөлт ажлын явцад хүүхэд бүр өөрчлөгдсөн байвал тэр нь төсөлт ажлын үр дүн юм. Товчдоо, үнэлнэ гэдэг нь аливаа зүйлийн өөрчлөлтийг олж харна гэсэн үг юм.

ДАДЛАГА- 4

Цуглуулсан мэдээлэлдээ боловсруулалт хийж, тайланд бэлтгэх

/60 мцн/

Алхам	Хугацаа	Багшийн үйл ажиллагаа	Оролцогчийн үйл ажиллагаа	Арга	Хэрэглэгдэхүүн
Алхам 1	10 мин	Мэдээллийн эх сурвалжаа тэмдэглэж явахыг сануулна	Өөрсдийн сонгосон сэдвээр цуглуулсан мэдээллүүдээ нэгтгэнэ. Уншин төрөлжүүлнэ.	Уншингаа тэмдэглэл хөтлөх, бүлгээр ажиллах арга	ppt слайд, багийн тоогоор мэдээлэл
Алхам 2	10 мин	Харилцан мэдээлэл солилцох орчин бүрдүүлнэ	Багууд мэдээлэлд боловсруулалт хийж, бусдадаа танилцуулах аргаа сонгоно	Асуудал дэвшүүлэх, мэдээлэл солилцох арга	ppt слайд, чихрийн цаас, өнгийн цаас
Алхам 3	15 мин	Мэдээллийг цэгцлэн нэмэлт тайлбар, дүгнэлт гаргахыг хүснэ	Мэдээллээ багцлан бусдадаа илтгэхэд бэлэн болгоно.	Үзэсгэлэн үзэх арга	ppt слайд, оролцогчдын бүтээл

Дадлага ажилд ашиглах материал

- Мэдээллээ төрөлжүүлэх, ангилах, тэмдэглэх, ярилцлага хийх. Мэдээллийн орчны нэг хэлбэр ярилцлага, ярилцлага хийхдээ тэмдэг лэл хөтлөх хуудсыг ашиглах загварууд

ĐÀÄÊÌ ÒÃĖÅÂÈÇÈÉÌ Ì ÝÄÝÝËÝË ÕÝÌ ÄÝÃËÝÕ ÕÓÓÀÑ

Нэр..... Огноо.....

Асуудал.....

1. Ì yáyýèèéí yō nōāāææ/Ōæāāæç ðāāèì æéí ì yáyýèèéí ð° ð° éá° ð, áàðèì òàò èéí î, yðèèèèāā áí èí í áónāā í yāòð; ðyāçyðæéāàø èæææáí èí î /

Í ýáòðççýǣ ççýæ ñî í ñî æ áàéðääà äî î ðð ãñóóèàä òàðèéèàð áýèðǣýý òäî ääàðæ.
 —çí ä:

2. Ýí ý àñóóäè ÷óõè àñóóäèûí í ýāì °í ¿¿? ßàãàä

Нэр.....
Огноо.....
.....

Ярилцлага өгсөн хүний нэр.....

/танил хүн, ахмад насны хүн, оюутан, бизнесмен гэдэг үйлдлийг багасгахгүйгээр /
үйлдлийг багасгахгүйгээр /үйлдлийг багасгахгүйгээр /үйлдлийг багасгахгүйгээр /үйлдлийг багасгахгүйгээр /

À. Ýí ý àñóóàè òàí û áí äëî î ð èéääýðëýäýè çî ðèð òóðàè àñóóàè ì °í ¿¿? ì °í бол яагаад?

.....Бусад хүмүүс ч гэсэн энэ асуудлыг чухалд тооцох болов уу?

Нэр:
Огноо:

Ōýâëýëèéí í ýď /î í , ñàď, ° ä° ď/

a. ä:ëëëéí
гарчиг.....

1. Óã ° Æçÿéä ñí í ã æ àâñàí àñóóäëúí òàèààð áàðèì òàèñàí áàéð ñóóðÿ

2. Ó ã á à é ð ñ ó ó ð è é í ã ë î í ö ë î ã

Энд хийсэн дүгнэлт төрсөн сэтгэгдэл

✓ Õýðõýí ñàéæðóóëæáî ëî õ âý?

Утас.....

Алхам 2	50 мин	Тайланд бэлтгэх аргачлал [1] өгнө	Багууд тайлангаа тавина. мэдээлэлтэй танилцаж, ярилцаж, тэмдэглэл хөтөлнө.	туршлага солилцох сонсонгоо тэмдэглэл хөтлөх	Зөөвөр бүхий ppt слайд, 9х9=81 нүд бүхий том хүснэгт, тайлангийн хувилбарууд, А-4 цаас, өнгийн цаас, ватум, эсгий бал, фото зургууд
Алхам 3	15 мин	Багуудад цаг тогтоох, тэмдэглэл хөтлөх (ямар ямар арга хэлбэрээр хамгаалж буйг)	Сонирхсон зүйлээ асууж ярилцана Ажиглагчид В2 хуудсыг бөглөнө.	Бүтээлч асуулт тавих	Асуултын жагсаалт, ажиглагчийн хуудас В2

Мэдээлэлд ашиглах материал

- Төсөлт ажлын судалгааны орчин нь багууд өөр өөрийн судалгааны материалиар орчин бүрдүүлж, тайланд бэлдэх үйл явц юм.
- Сонгосон сэдвийнхээ дагуу судлагаагаа хэрхэн хийснээ бусдадаа танилцуулна. Оролцогчид туршилтын явцад “Бичил судалгаа” хийсэн баг бүрийн 3 дугаартай оролцогчоос эхлэх ярих явцад нэмэлт санааг тэмдэглэнэ.
- Галерей үзэх аргаар оролцогчдыг судалгааны орчноор аялуулах, аялж явахдаа:

- 1) Өөр өнгийн эсгий балаар өөрийн санааг нэмж бичих
- 2) Өөрт авсан санаагаа дугуйлж үлдээх
- 3) Эргэж дахин ярилцан дараагийн төлөвлөлтийг хийх


Дадлага ажилд ашиглах материал

- Хичээлд ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөх зарим аргууд.

• Хичээлд ажиглалт хийх явцдаа тэмдэглэл хөтлөх аргазүйд суралцаарай. • Эдгээрээс санаа авч багш бүр өөрийн гэсэн тэмдэглэх аргазүйг бүтээгээрэй.	<u>1.Үгчлэн тэмдэглэл хөтлөх арга</u> Ажиглуулагчийн хэлж байгаа үгийг тэр чигээр нь / үг нэмэхгүй, үг хасахгүй ажиглагчийн санаа орохгүйгээр / бичихийг үгчлэн тэмдэглэх арга гэнэ. 3 хэсгээс бүрдэнэ. Эхлэл / огноо/ Гол хэсэг /ажиглуулагчийн хэлсэн үг/ Төгсгөл /ажиглагч багшийн санал дүгнэлт/
--	---

<u>Жишээ</u> Ажиглуулагч багш Булган аймаг 1-р Бүрэн дунд сургуулийн Монгол хэлний багш Д. Алимаа - Эхлэл 2012.02.28 өдөр Булган сум - Гол хэсэг -Хүүхдүүд ээ! Та нар яагаад хичээлдээ идэвхтэй оролцохгүй байна вэ? Хүн хичээлд суухаар сандраад байна уу? Бүү сандар. Та нар чадна ш дээ! - Дүгнэлт Дээрх багшийн хэлсэн үг нь олон багш хичээлд суухад хариулт өгөх итгэлгүй байсан сурагчдын айдсыг даван туулахад нь урам хайрлан, итгэл өгч, хичээлдээ анхаарлаа төвлөрүүлэхэд нь чиглүүлсэн. Ажиглагч багш Л.Намуунтуяа	<u>2. Хугацаат тэмдэглэл хөтлөх</u> 1) Ажиглах зорилго, цагийг тодорхойлох / сурагчдын идэвх оролцоог 12.00-13.00 гэх мэт/ 2) Давтамжаа сонгон, тэмдэглэл хөтлөх /20 минут / 12.00 тэмдэглэл 12.20 тэмдэглэл 12.40 тэмдэглэл 13.00 тэмдэглэл				
<u>3. Үйл үгээр тэмдэглэл хөтлөх</u> - Ажиглах зорилгоо тодорхойлох - Үйл бүрийг тэмдэглэх \ цаг минуттай нь \ 12.00 бичиж байна. 12.15 бодлоо. 12.30 ганцаараа үлдэв. гэх мэт - Ажиглагчийн дүгнэлт	<u>4. Сэргээн санаж тэмдэглэл хөтлөх.</u> - Бүх зүйлийг тэмдэглэнэ. - Шаардлагатай үед сэргээн санаж өөрийн болгон тэмдэглэл хөтлөх - Ажигчийн дүгнэлт огноо бичих				
<u>5. Тохиолдлын тоог олж тэмдэглэл хөтлөх</u> <u>Жишээ</u> 2 гэсэн тоог сонголоо гэж бодъё. Тэгвэл хаалттай нээлттэй асуулт, эсвэл эр, эм сурагчдын оролцоо гэх мэт 2 зүйлийг харьцуулж ажиглана гэсэн үг. - Ажиглагчийн санал дүгнэлт, огноо бичих	<u>6. Зураасаар тэмдэглэл хөтлөх арга</u> - Судлах зорилгоо тодорхойлох /эр, эм сурагчдын оролцооны харьцаа/ - Тэмдэглэгээгээ зураасаар тэмдэглэх жишээ нь <table border="1" data-bbox="933 1209 1316 1288"> <thead> <tr> <th>Эрэгтэй сурагч</th> <th>Эмэгтэй сурагч</th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table> 6.3 Дээрх байдлаас дүгнэвэл эмэгтэй суралцагчдын оролцоо эрэгтэй суралцагчдын оролцооноос их байна. - Дүгнэлт : Цаашид эрэгтэй сурагчдын оролцоог нэмэгдүүлэх талаар багш анхаарах	Эрэгтэй сурагч	Эмэгтэй сурагч		
Эрэгтэй сурагч	Эмэгтэй сурагч				

- Хэлэлцүүлэгт хэрэглэх зорилготой явцыг дэлгэрэнгүй бичсэн урт цаас.



- Бусад оронд хичээл ажиглалтын явцад 1 багш хичээлийн явцыг дэлгэрэнгүй тэмдэглэж, хэлэлцүүлэгт оролцогчдод олшруулж өгдөг байна. Энэ тохиолдолд оролцогчид түүн дээрээ шууд тэмдэглэж болно.

- Харин манайд нөхцөл байдлыг тооцож үзвэл, хичээлийн явцыг урт цаасан дээр /Факсын цаас илүү тохиромжтой байдаг/ флөмөстераар, томоор харагдахуйц бичээд хэлэлцүүлэг хийх өрөөний хананд байрлуулах аргыг “Төсөлт ажил” багийнхан санаачлан туршсан ба энэ нь олон талын /Хичээлийн аль хэсэгт ямар санал хэлэхээ баримжаалах, цаас, цаг хэмнэх, санал давхардуулалгүй ярих г.м/ ач холбогдолтой байлаа. Мөн хичээлийн явцад тухайн нөхцөл байдлаас шалтгаалаад хичээлийн хөтөлбөрөөс гадуур үйл ажиллагаа явагддаг тал байдаг. Үүнийг алдалгүй тэмдэглэж аваад хэлэлцүүлэгт ашиглах зэрэг ач холбогдолтой.

-Хэлэлцүүлэгт биечлэн оролцож амжихгүй тухайн цагт хичээлтэй багш нар хичээлийн яг аль хэсгийг сайжруулах талаар өөрийн санал, шийдэл, гарцаа цаасан дээр бичээд, яг тухайн хэсэгт нь наана.



- Судалгааны үйл явцыг танилцуулах хичээлийг хөтөлж чиглүүлэхэд:
 - Багшийн чиглүүлэг (Судалгааг хөтлөх түлхүүр үг бэлдэх, судалгааны орчинг бэлдэх, судалгааны боловсруулалтад бэлдэх, зочин урихад удирдамж бэлдэх, судалгааны хэлэлцүүлэгт бэлдэх)
 - Багийн чиглүүлэг (Багийн танилцуулах хуваарь, багийн гишүүд судалгаагаа танилцуулахад бэлдэх, багийн гишүүд бие биенээсээ санаа авах тэмдэглэл хөтлөх,
 - багууд судалгаанаа явцад өөрийн дүгнэлтийг хийхэд бэлдэх, багууд дараагийн төлөвлөлтийг хийх)

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ- 1

Төсөлт ажлын тайланг хэрхэн хийж болох вэ?

Туршлага солилцох мөч

/90 мин/

Үе шат	Арга	Хэрэглэгдэхүүн
Асуудал дэвшүүлэх “Төсөлт ажлын тайлан ямар хэлбэртэй байж болох вэ?	“Тасалсан тууз” арга	ppt слайд, цаасан тууз
Санал солилцох	Үзэг шилжүүлэх арга	Заавар бүхий ppt слайд, санал сэтгэгдлээ бичих том цаас
Дүгнэлт гаргах	3-2-1	ppt слайд, оролцогчдын дүгнэлтийг бүлэглэх цаас

Хэлэлцүүлэгт ашиглах материал

- **“Тасалсан тууз”** арга: “Миний бодлоор төсөлт ажил ...”
Оролцогч бүрт өнгийн тууз өгч өөрийн хүссэн хэмжээгээр тасалж авахыг хүснэ.
Авсан туузныхаа хэмжээгээр “Миний бодлоор төсөлт ажил” сэдвээр өөрийн бодлыг ярихдаа туузаа эвхэж, дуустал ярих гэх мэт оролцогч бүрийг яриулна.
- **“Үзэг шилжүүлэх”** арга: Оролцогчид өөрийн туршлагыг ярьж, ярьсан зүйлийнхээ гол санаагаа тэмдэглээд дараагийн ярихыг хүссэн оролцогчдод үзгээ шилжүүлэн өгнө. Шилжүүлэн өгөхдөө уриалсан бичихийг хүссэн сайхан үг хэлж өгнө.

МЭДЭЭЛЭЛ - 5


- **Төсөлт ажлын тайлангийн хэлбэрүүд**
- **Тус бүрийн онцлог**

/180 мин/

Төсөлт ажлын тайлангийн хэлбэрүүдэд:

- Үзэсгэлэн гаргах (галарейн арга)

- ᠱᠣᠳᠤ ᠨᠢᠭᠡᠰᠦ᠋ᠨᠢ ᠶᠢᠨᠪᠠᠭᠠᠳᠤᠳᠤᠳᠤᠳᠤ /Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж 1-ээс дэлгэрүүлж уншина уу/
- Дүрд тоглох,соддәй ажаг буюу камишибай /Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж 1-ээс дэлгэрүүлж уншина уу/
- Ханын сонин, ном бүтээх, мэдээлэл, фото тайлан /Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж 1,2,3 -аас дэлгэрүүлж уншина уу/
- Зохион бичлэг /чөлөөт зохион бичлэг/, эсээ бичих /Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж 1-ээс дэлгэрүүлж уншина уу/
- Чөлөөт ярилцлага явуулах г.м-ээр нэрлэж болох ч хамгийн гол нь дээрх хэв загварт баригдалгүйгээр хүүхдүүдээр өөрсдөөр нь чөлөөтэй сэтгүүлж бодуулж тайлан тавиулах нь чухал гэдгийг анхааруулах

“МЭДЭЭЛЭЛ-5”-д ашиглах ppt-ийн зарим зургийн тайлбар 2月15日(日) 肉 スー  おいしー しょうゆ味 作り方 1. 鍋に肉、玉ねぎ、人参、水を入れて煮る。肉が柔らかくなったら、しょうゆを加える。 2. それをお皿に盛り、お好みでいりこを入れる。 3. お好みにお米を炊き、しょうゆ味の肉汁をかける。お好みでいりこを入れる。 とってもかんたん に作れちゃう。 (阿部 隆子)	Чөлөөт зохион бичлэг Бөөрөнхий махтай шөлийг хэрхэн хийх аргачлалыг бичжээ. Зөвлөмж 1 49 дэх тал
リボンさん(おまじ) 私は、リボンさん。水玉もようのかわいいリボンは、たねが買ってくれなかな。お母さん、お父さん、リボンを買ってこのリボンあきた。はいはい。このリボンは、(111)の「あの水玉の」も、たねを買った。買われるのね。女の子がリボンさんとつけた。かわいー。前のリボンは、買はつけよ。そして、一週間後。あ、かあさん。このリボンあきた。はいはい。どれが、え？アア？そして、お母さん、買はつけられた。この前のリボンがつけられた。服に。あ、女の子が、(111)の前のリボンが言、た。あ、も、なはと、思、た。けど、(111)話、相手か、で、き、良、か、た、わ、で、して、お母さんと前のリボンは、あ、た、ち、な、た、う。 	Дэлгүүрийн лангуун дээр байгаа үсний зүүлтүүд, хэрвээ ярьж чаддаг байсан бол хэрхэн хөөрөлдөх байсныг өгүүлжээ. Зөвлөмж 1 – 50 дахь тал
	Өртөөчилсөн сугалаат худалдаа Өртөөгөө сурталчилж буй хүүхдүүд өртөө өртөөнийхөө дугаарыг өргөөд талбайн голд явж байна. Тухайн өртөө олон үйлчлүүлэгчийг татахын тулд өртөөгөө сурталчилдаг. 3-р ангийн сурагчид цэцэрлэгийн дүү нараа дагуулан мэдээлэл өртөөн дээр ирж байгаа нь (Ногоон малгайтай нь

	цэцэрлэгийн хүүхдүүд) Зөвлөмж 1 54 дэх тал
	“Эрдэнэсийн арал” нэртэй өртөөний байдал. Энэхүү өртөөнөөс авах шагналын зүйлээ сонингоор хийсэн арал дотроос өөрсдөө олж авч байв. Зөвлөмж 1 55 дахь тал
	Өртөөн дээр ирсэн хүүхдүүдэд цаасан жүжиг тоглож байгаа нь Зөвлөмж 1 56 дахь тал



Зааланд нийтдээ 12 өртөө ажиллаж байна.

Зөвлөмж 1 57 дахь тал



“Хэн нь хамгийн гоё уут хийх вэ?” уралдаан зарлаж дүгнээд шалгарсан уутнуудыг дэлгэж үзүүлсэн байдал \Сэлэнгэ аймаг 1-р сургууль\

Зөвлөмж 3 76 дахь тал



Төсөлт ажилд эцэг эх, олон нийт оролцож, хүүхдүүдийн ажилд дэмжлэг тусалцаа үзүүлж, тайлагнахад нь хамтдаа байх нь хүүхдүүдэд улам их урам итгэл өгч, өөрчлөгдөж байгаагаа харуулах сайхан боломж өгдөг.

Зөвлөмж 3 115 дахь тал


Усны дусал багийнхан устай холбоотой, өргөн хүрээтэй судалгаагаа 81 нүдний аргаар багцлан гаргажээ. Тус бүртээ 9 нүд бүхий асуудлыг багийн гишүүн бүр нэг нэгээр нь ярьж хамгаалсан нь сонирхолтой байв.

Зөвлөмж 3 146 дахь тал



Судалгааны явцад Сүхбаатарын талбайг цэвэрлэдэг үйлчлэгч нартай уулзаж ярилцлага авч байгаа нь

Зөвлөмж 1 31 дэх тал



Энэхүү графикт босоо шугаманд 0-90 хүртэл оноо, хэвтээ шугаманд тухайн багийн сурагчдын нэрийг бичиж, тэдний ажлын үр дүнг үнэлжээ.

Зөвлөмж 1 59 дэх тал

МЭДЭЭЛЭЛ-6

Төсөөт ажлын үнэлгээ

/40 мин/

“МЭДЭЭЛЭЛ-6”-д ашиглах ppt-ийн зарим зургийн тайлбар

Төсөлт ажлын үнэлгээг өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ гэсэн 2 хэлбэрээр хийж болно.

- Өөрийн үнэлгээг хийлгэхдээ тухайн төсөлт ажлыг хийхийн өмнө юу юу мэддэг, чаддаг байв, төсөлт ажлын явцад юу юу мэдэж сурч, хийж чаддаг болов гэдгийг яриулж, бичүүлж /“Portfolio”-ийн аргаар/ болно.

- Тухайн сурагчийг ахицаар нь үнэлэх
- Явцын хяналт үнэлгээ хийж байх
- Багийн гишүүдийн идэвх оролцоог тооцож хянаж үнэлж байх
- Хүүхэд бүр “Porteolio” хавтастай байх



Portfolio –ийн жишээ (Монгол)



Гуравдугаар ангийн сурагчдад үнэлгээ өгөхдөө маш сонирхолтой хэлбэрийг “Урамшууллын карт”, “Бэлгийн карт” г.м.\ хэрэглэсэн жишээ

СБД 45-р сургууль

/180 мин/

Үе шат	Хугацаа	Алхам, агуулга	Арга	Хэрэглэгдэхүүн
Эхлэл хэсэг	30 мин	Төсөлт ажил-интеграц хичээл	Судалгааны хэсэг ажиллуулах хэсэг	Хайчилбараас бүтсэн сонин, ном, зөвлөмж, гарын авлага, ppt слайд,
Үндсэн хэсэг	60 мин	Төсөлт ажил ба тогтвортой хөгжлийн боловсрол Төсөлт ажлын стандарт \япон\	“Санал нийлж байна, санал нийлэхгүй байна” арга	ppt слайд, булангуудын нэр хаяг, өгөгдөл өгүүлбэрүүд
Төгсгөл хэсэг	30 мин	Төсөлт ажил ба төсөлт хичээл	Веннийн диаграммын арга	Харьцуулалт хийх диаграмм, зөв хувилбар

Мэдээлэлд ашиглах материал

- Хүмүүс байгаль ахуй, нийгэм ахуйн хүрээнд амьдардаг бөгөөл эдгээр нь хоорондоо нарийн уялдаа холбоотой байдаг. Байгаль ахуйг судалдаг Байгалийн ухаан, нийгэм ахуйг судалдаг Нийгмийн ухаан хүчтэй хөгжсөн боловч тус бүртээ зам мөрөө хөөж хөгжсөн нь хүн төрөлхтний глобаль асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй тулгарсан. Ийм учраас байгаль, нийгмийн асуудлыг уялдаа холбоонд нь авч үзэн, тогтвортой хөгжих хэрэгцээ шаардлага хүн төрөлхтний өмнө тулгарч байна.
- Тогтвортой хөгжил.** тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд “Тогтвортой хөгжлийн гурвалжин” гэсэн нэр томъёог хэрэглэдэг бөгөөд энэ нь:
 - Эдийн засгийн хөгжил
 - Нийгмийн хөгжил
 - Экосистемээ хадгалах асуудлыг нэг нь нөгөөгөө золиослохгүйгээр, тэнцвэртэй авч явах санааг илэрхийлнэ.
- Тогтвортой хөгжлийн гол үзэл санаа нь хамгийн эрхэм сайхан зорилгод хүрэхийн тулд өөрийгөө болон бусдыг, мөн өнгөрснөө, өнөөдрийгөө болон ирээдүйгээ золиослохгүйгээр ажиллаж, амьдрах арга ухааныг төлөвшүүлэхэд чиглэж байгаа учир хувь хүний ёс зүй, хандлага төлөвшил, үнэт зүйлийн үнэлэмжтэй ихээхэн холбоотой.
- Тогтвортой хөгжлийн шавхагдашгүй нөөц нь хүний нөөц гэж үзэж, энэ нөөцийг улам хөгжүүлж, арвижуулахад нөлөөлдөг шийдвэрлэх хүчин зүйл нь тэдний боловсролын чанар, эх ундарга нь иргэдийн тасралтгүй суралцах үйл ажиллагаа гэж тодорхойлдог. Өргөн хүрээнд авч үзвэл, боловсролын энэхүү тогтвортой хөгжлийг хангахад, явцуу хүрээнд авч үзвэл, ажил, амьдралдаа тулгарсан асуудлыг бүтээлчээр, хариуцлагатайгаар, өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжлийн үзэл санааны дагуу шийдвэрлэх бодит мэдлэг, чадвар, хандлага, ёс зүйг эзэмшүүлэхэд төсөлт ажил маш чухал нөлөөтэй юм.
- Ер нь хүний амьдралыг олон төрлийн шийдвэрүүд, тэдгээрийн гүйцэтгэлийн тогтолцоо гэж үзэж болно. Хүн гаргасан шийдвэр бүрээ өөртөө амар хялбар, ашигтай хэрэгтэй байхаар гаргадаг. Гэтэл шийдвэр гаргаж байгаа хүнд:

1) Бие хүний сонирхол

- 2) Хувь хүний хүсэл
- 3) Гэр бүлийн эрх ашиг
- 4) Хамт олны ашиг сонирхол
- 5) Байгууллагын эрх ашиг
- 6) Бүлгийн ашиг сонирхол
- 7) Үзэл бодол нэгтнүүдийн ашиг сонирхол
- 8) Нутаг усныхны нийтлэг сонирхол
- 9) Үндэсний ашиг сонирхол
- 10) Бүс нутгийнхны ашиг сонирхол
- 11) Хүн төрөлхтний нийтлэг ашиг сонирхол гээд олон эрх ашиг хөндөгдөж байдгийг тэр бүр анзаардаггүй байж болно.

- Хүн шийдвэр гаргахдаа олон эрэмбэтэй ашиг сонирхлын аль нэгийг урьдал болгодог. Эдгээр ашиг сонирхлоос хүн төрөлхтний нийтлэг ашиг сонирхлыг хамгаас дээр тавин, жагсаалтыг урвуулан эрэмбэлж, шийдвэр гаргаж байгаа хүн бол өндөр ёс зүйтэй хүнд тооцогдоно.
- Боловсролтой иргэний шинж чанар, төлөвшил нь цогц чадамжуудаар, цогц чадамж нь сургалтаар эзэмших ур чадваруудаар тус тус тодорхойлогдоно.
- Төсөлт ажлын нэг онцлог бол хүүхэд, багшийн аль аль нь хичээлийн төлөвлөлтийг мэдэж байх ёстой. Хүүхдүүд багшаас урьдчилан авч судалж эсвэл багш танилцуулж болно. Төсөлт ажил явуулах багш хүнд үзүүлэх, харуулах хичээл бус, хүүхэд рүүгээ чиглэсэн хичээл заах нь чухал.

Төсөлт ажлын стандарт Япон

• Анх 1998 онд ЕБС-ийн стандартын ерөнхий хэсэгт тайлбар төдий оруулсан байдаг.

• 2000 оноос албан ёсоор ТА орж эхэлсэн.

• 2008 онд ТА-ын бие даасан стандарт зохиогдсон.

• 2011 он хүртэл засаж сайжруулсан

• 2011-2012 оны хичээлийн жилээс мөрдөгдөж эхэлсэн

ТА-ыг стандарттай болгосны учир:

1. ЕБС-д 2000 оноос орж эхэлсэн ч эргээд харахад сургууль бүрт харилцан адилгүй явагдаж байсан.
2. ТА нь хэдийгээр хүүхдийг хамгийн их хөгжүүлдэг нь батлагдсан ч юу заах нь тодорхойгүй байсан учир зарим сургууль, багш ТА-ийнхаа цаг дээр үндсэн хичээлийнхээ давтлагыг хийж байсан зэрэг сөрөг хандлагууд ажиглагдсан.

Дээрх 2 асуудлаас үндэслээд ТА-ын бие даасан стандартыг бий болгож ТА явуулахад баирмтлах зарчим, хүүхдэд ямар чадвар эзэмшүүлэх, багш нар ТА-ын сургалитын орчныг хэрхэн бүрдүүлж ажиллах талаар тодорхой оруулж өгсөн байна.

Агуулгын хүрээний хувьд:

- ✓Сурагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн
- ✓Сум орон нутаг, сургуулийн онцлогийг харгалзсан
- ✓Олон улсын ойлголт

Хичээлийн хуваарьт зоогдох ТА-ийн цагийн нэрийн хувьд:

✓Сургууль онцлогтоо тохируулаад өөр өөрөөр нэрлэж болно. Жишээ нь: “Орчлон хорвоогийн амьдрал”, “Бид чадна” г.м.

\\ТА-ын стандарт” 116 дахь тал\

Аргазүйн төлөвлөлтөө боловсруулахдаа:

1. Зорилго, зорилт
2. Сурагчдад эзэмшүүлэх чадвар, төлөвшил
3. Дэлгэрэнгүй агуулга
4. Сурагчдын үйл ажиллагаа
5. Явуулах аргазүй
6. Сурагчдын үнэлгээ
7. Сургуулийн удирдлага, багш нарын хамтын ажиллагааны менежмент зэргийн оруулсан байх


\\ТА-ын стандарт” 94 дэх тал\

Багш нарын хамтын ажиллагааны тухайд:

Анги нэгдлээрээ ямар агуулга судлахаа сургуулийнхаа ерөнхий төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох

\\ТА-ын стандарт” 99 дэх тал\

- Төсөлт ажлын үед төлөвлөлт хамгийн чухал.



№	Үе шат	Тайлбар
1	Сэдэл	Яагаад, ямар учраас энэ сэдвийг сонгох болсноо бичнэ.
2	Төсөөлөл	Энэ сэдвийг ямар байдлаар, яаж судлахаа урьдчилан төсөөлнө.
3	Судалгаа	Судалгааны агуулга, чиглэлээ тодорхойлно.
4	Судалгааны арга	Ном зохиол буюу бичгээр илэрхийлсэн материалуудыг унших судлах, эргэн тойрны хүмүүсээс асуух, сонсох, ярилцах, туршилт хийх гэх мэт судалгааны ямар арга сонгохоо бичнэ.
5	Судалгааны дүгнэлт тайлан	Судалгаагаа хэрхэн, яаж нэгтгэн дүгнэж, ямар арга, хэлбэрээр тайлагнахаа бичнэ.

Ингэхдээ асуудал дэвшүүлэхэд шаардагдах сурагчдын авьяас, чадвар, төлөвшлийг чухалд үздэг байна. Тэдгээрийг “**судлах арга барил**” гэсэн ойлголтод багтаан, **мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, нэгтгэн дүгнэх, тайлагнах зэрэг үйл ажиллагаанд тулгуурласан мэдлэг, чадвар гэж үзсэн ба эдгээр нь “амьдрах ухаан”-ыг аргын хувьд дэмжиж өгнө.**

- Сурах ур чадварыг эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа буюу **үндсэн үе шат**
- Асуудлыг олж харах, томъёолох, дэвшүүлэх, шийдвэрлэх үйл ажиллагаа буюу асуудал дэвшүүлж **судлах үе шат** гэсэн 2 үе шаттай.

Ингэж төлөвлөснөөр бусад хичээлүүдээр олж авсан мэдлэг, чадвар хийгээд төсөлт ажлаар эзэмшсэн сурах ур чадвар нь сурагчид асуудал дэвшүүлэн судлах, шийдвэрлэхэд харилцан бие биеэ нөхөн, нэгдэж хамтарч болно хэмээн үзжээ. Хичээлээр шийдвэрлэхэд хэцүү төвөгтэй асуудлыг төсөлт ажлаар шийдвэрлэхийг зорьсон. Өөрөөр хэлбэл, **төсөлт хичээлийг** зохион байгуулна гэсэн үг. Ер нь дунд ангид төсөлт ажил болон төсөлт хичээлийг яламжтай авч үзвэл зохино. Үүнд:

Бие даасан төсөлт ажил болон төсөлт хичээл нь тус тусдаа явагддаг ч бие биетэйгээ уялдан шүтэлцэж байдаг тул тэдгээрийг маш нарийн уялдаа холбоонд нь авч үзнэ.
/”Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж 3 –аас үзнэ үү/

- **Тухайн хичээлийн жилийн төсөлт ажлын төлөвлөлт**
- **Төсөлт ажлын тухайн улирлын төлөвлөлт**
- **Төсөлт ажлын тухайн 7 хоногийн төлөвлөлт**
- **Төсөлт ажлын тухайн өдрийн төлөвлөлт буюу 1 цагийн хичээлийн хөтөлбөр**

ТӨСӨЛТ АЖЛЫН НЭГ ЦАГИЙН ХӨТӨЛБӨР

Жил, улирал, сар, өдрийн төлөвлөлтүүдээс яг тухайн цагийн өөрөөр хэлбэл хичээлийн нэгжийн (хичээлийн нэгжийн тодорхойлолтыг төслийн хүрээнд гарсан “Төсөлт ажлын аргазүй” зөвлөмж 1-ийн хавсралтаас харна уу) хичээлийн онцлог, үр дүн болон сурагчдын эрэлт хэрэгцээг онцгой харгалзан үзэж байж дараагийн цагаа төлөвлөх нь зохимжтой. Өөрөөр хэлбэл төсөлт ажлын хувьд тухайн улиралд танхимд орох 5 цагийг урьдчилж нэг зэрэг төлөвлөх аргагүй гэсэн үг. Заавал өмнөх тайлангийн үр дүнгээс дараагийн цагийг хэрхэн төлөвлөхөө тооцно гэж ойлгож болно. Төслийн хүрээнд бага болон суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг туршсан багш нар хэдийгээр төсөлт ажлаа хэрхэн төлөвлөх талаар туршлага бага байсан ч өөр өөрийн гэсэн арга барилаар тухай бүр төлөвлөж байсан бөгөөд зарим жишээг дор орууллаа. Заавал яг ийм хэлбэр загвараар биш өөр ямар ч байдлаар төлөвлөж болох нь та бүхэнд нээлттэй гэдгийг хэлье. Ер нь бусад хичээлүүдийн адил бүх явцыг урьдчилан төлөвлөх боломжгүй ч дараах байдлаар ерөнхий төлөвлөж болох юм гэж үзэж байна. Харин багш хичээлийн явцад сурагчдын ярианы гол санаа, шинээр дэвшигдэж буй асуудал, нэмж тайлбарлах зүйл зэргийг байнга тэмдэглэл хөтлөх нь практик ач холбогдолтой болохыг манай туршсан багш нар маань ярьдаг юм. Ерөөсөө төсөлт ажлын явцад багш тогтмол тэмдэглэл хөтлөх шаардлагатай байдаг. Ингэж чадвал төсөлт ажлын гол зүйл болох “үйл явц”-д анализ хийж сурагчдаа хөгжих төлөвшихөд нь тусалж чадна гэсэн үг. Энэхүү төлөвлөлт нь “ЕБС-ийн 12 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”-нд 3-6 р ангид долоо хоногт нэг цагаар суугдаж өгсөн “Төсөлт ажил” гэсэн цагийн төлөвлөлт болно. Энэ төлөвлөлтийг хэрхэн хийж болохыг дараах хөтөлбөрөөр жишээ болгон харна уу.

Сэдэв/агуулгын хүрээ: “БИ УГИЙН БИЧГЭЭ ЗОХИОЛОО”

Хамрах хүрээ: Сэлэнгэ аймгийн төвийн 4-р 11 жилийн сургуулийн 7^б анги

Хугацаа: 2008.2.26 (танхим 212, эцсийн тайлан)

Боловсруулсан багш: Д.Нарантуяа

Зорилго: Гэр бүл, удам угсаагаа мэдэж бахархах үзэл төлөвшүүлэх

Зорилт:

- Суралцагчид хичээлээр олж авсан мэдлэгээ хэрэглээ болгох чадварт сурах
- Бусдад өөрийгөө нээх боломж олгох

Хэрэглэгдэхүүн:

- “Монгол улсын угийн бичиг хөтлөх гарын авлага”
- 9-р ангийн эрүүл мэндийн сурах бичиг
- English-3 сурах бичиг
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын иргэн И.Цоодол гуайн хөтөлсөн угийн бичиг
- Ватум цаас, фламастер, өнгийн цаас

Хэрэгцээ:

1. Гэр бүлийн уламжлалыг дээдлэн, удам угсаагаа мэдэх
2. Удамшлийн өвчин эмгэг, оюун ухааны хомсдолтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх
3. Цус ойртохоос сэргийлэх

Агуулгын залгамж холбоо:

Өмнө судалсан агуулга	Цаашид судлах агуулга
▪ Монголчууд үр хүүхдэдээ нэр хэрхэн өгдөг зан үйл, уламжлал ▪ Нэр цээрлэх ба зерүүлэх ёс ▪ Нэрээ эрхэмлэн хайрлахын учир ▪ Угийн бичгийг хөтлөхийн ач хобогдол	▪ Гэр бүл болоцох, хуримлах ▪ Насны ой тэмдэглэх ▪ Хүүхдийн даахь үргээх ▪ Хүүхдийг угаах зэрэг зан үйлийг судлах

Судлагдахуун	Ур ухаан
Миний зохиосон угийн бичиг нь гэр бүлдээ оруулсан том хувь нэмэр	▪ Асуудлыг олж харах, дэвшүүлэх чадвар олох ▪ Өөрсдийн сонирхсон зүйлээ судалж мэдэх нөхцөл бүрдүүлэх ▪ Хүүхдэд сурах, судлах барилын хандлага төлөвшүүлэх

Аргазүйн зохион байгуулалт: Асуудал дэвшүүлж шийдвэрлэх

Сурагчдыг 4 багт хувааж ажиллуулна. Баг бүр өөрсдийн зохиосон угийн бичгийн давуу талыг гаргаж хэлэлцэнэ.

Хичээлийг сурагч Хонгорзул, Гантогтох, Амартүвшин нар удирдан явуулна.

Хичээлийн үйл явц:

Үйл явц	Сурагчдын үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг	Анхаарах зүйл
Сурагчдын дотоод нөөцийг илрүүлэх, асуудал дэвшүүлэх	1. Сэдвийн тороо товч танилцуулах 2. Өмнөх хичээл дээр сурч мэдсэнээ сэргээн санах 3. Үгийн сүлжээ бөглөх	Үйл явц болон сурагчдын яриаг анхааралтай сонсож, чиглүүлж дэмжих	Сурагчдыг ярих явцад багш байнга тэмдэглэл хөтлөх
Шинэ мэдээлэл солилцох мэдлэг бүтээх	▪ Өөрсдийн зохиосон угийн бичгээ тайлбарлах ▪ Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, хөтлөхгүй байхын хор уршгийг дүрээр тоглож үзүүлэх	Угийн бичгээ хэрхэн чаж хийснийг анхааралтай харж нэмэлт зөвлөгөө өгөх	▪ Сурагчид бусдынхаа яриаг хэр анхааран хүлээж авч, ойлгож байгааг багш ажиглах ▪ Бусад нөхдөдөө сонсогдо хоор ярихыг анхааруулах
Бататгах, шүүн ярилцах, нэгтгэн дүгнэх	▪ Өөрсдийн зохиосон угийн бичгийнхээ давуу талыг ярих ▪ Аль загвараар угийн бичгээ хөтлөхөө сонгох ▪ Үнэлгээний багийнхан сурагчдын хийсэн ажилд үнэлгээ өгөх	Сурагчдад товч тодорхой цэгцтэй ярихыг анхааруулж явах	▪ Сайн сонирхол ▪ той хийсэн угийн бичгүүдийг ангийн хананд тогтмол байрлуулах ▪ Цэгцтэй ярьж буй сурагчдаас үлгэр дуурайл авахыг сануулах

МЭДЭЭЛЭЛ-8

“Төсөлт ажлын арга зүй” кино үзүүлэх

50 мин

- Оролцогчид багийн сургалтаар олж авсан мэдээллээ бодит жишээнээс харж ойлголтоо нэгтгэн дүгнэнэ.
Бичлэгээ үзүүлэхийн өмнө гол гол хэсгүүд дээр дараах зүйлүүдийг анхаарч ажиглахыг урьдчилж сануулна.

Юуг ажиглах вэ?

Багшийн хувьд

- ✓ мэдрэмж
- ✓ чиглүүлэг
- ✓ оролцоо
- ✓ нэгтгэх дүгнэх чадвар
- ✓ үнэлгээ

Сурагчийн хувьд

- ✓ сонирхолтой үйл, асуулт
- ✓ сэтгэл хөдлөл
- ✓ сонсох чадвар
- ✓ оролцоо
- ✓ Өөрийн болон чацуутны үнэлгээ

- ✓ СЭДЭВ СОНГОЛТ – ын хэсгээс багшийн мэдрэмж, багийг хэрхэн бүрдүүлж буй байдал, хүүхдийн хэрэгцээ сонирхол, хүүхдийн хандлага хэрхэн өөрчлөгдөж буй байдал,
- ✓ СУДАЛГАА-ы хэсгээс сонирхсон зүйлтэйгээ холбоотой материалыг хэрхэн эрж хайж, хийж судалж сурч буй байдал,
- ✓ ТАЙЛАН-ийн хэсгээс хүүхэд хичээлээр олж авсан мэдлэг чадвар туршлагаа хэрхэн хэрэглээ болгон ашиглаж илтгэж буй байдал, бусдадаа зааж сургаж буй байдал

- Төгсгөлд нь төсөлт ажлын талаарх ойлголтоо нэгтгэж, ярилцана.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ- 3

Багийн нэгдсэн хэлэлцүүлэг

- Багийн үндсэн оролцогчдоос судалгаа авах **(Багийн сургалтын хамгийн сайн тал нь юу байв? Юу юуг шууд хэрэглэх боломжтой вэ? Цаашид юуг шинээр мэдмээр, судалмаар байна?)**
- **“Төсөлт ажлын үндсэн баг-оролцогч багш нар-сургууль-оролцогч багш нар”** гэсэн холбоогоор цаашид хамтран ажиллах болон түгээн дэлгэрүүлэх баг бүрдүүлэх, үйл ажилагааны чиглэл гаргах

/60 мин/

Үе шат	Арга	Хэрэглэгдэхүүн
Асуудал дэвшүүлэх	“ТА”багийн сургалтаар сурч мэдсэнээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?	СХД-ийн 67-р сургуулийн багш Болортолийн

		тайлан А3 цаасаар гаргаж хананд байрлуулах \хамтын ажиллагаа\
Санал солилцох	Санал бодлоо бүлэглэн хуваалцах арга	Заавар бүхий ppt слайд, санал бодлоо бүлэглэн хуваалцах том цаас, нэгтгэх хүснэгт
Дүгнэлт гаргах	Тэргүүлэгч асуудлыг тодорхойлох 3-2-1 арга	ppt слайд, чухал санааг жагсаан бичих том цаас

Хэлэлцүүлэгт ашиглах материал

“Төсөлт ажил” –ын аргазүйг туршиж, түгээн дэлгэрүүлсэн ажлын товч тайлан Төслийн туршигч багш: СХДүүргийн 67-р сургуулийн МХУЗ-ын багш Б.Болортоль	11-р сарын сургалтанд хамрагдсанаар сургууль дээрээ дунд, бага ангийн төсөлт ажил хичээлийг туршин явуулах 2 багийг зохион байгуулж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. <u>Дунд ангийн төсөлт ажлын баг</u> 1. Б. Болортоль:МХУЗ-ын багш 2. Э.Шинэбилэг:МХУЗ-ын багш 3. З.Отгонсүрэн:Гадаад хэлний багш 4. М.Энхсайхан:Гадаад хэлний багш 5. В.Лайжханд:МХУЗ-ын багш 6. Д.Энх-Оюун:Түүхийн багш 7. С.Эрдэнэчимэг:Гадаад хэлний багш 8. С. Нямсүрэн:МХУЗ-ын багш
<u>Бага ангийн төсөлт ажлын баг:</u> 1. Ш.Ихтамир 2. З.Анхбаяр 3. Б.Батчимэг 4. Э.Тунгалаг 5. М.Оюун 6. Э.Мөнгөнтуяа	• 2010 -12 сард сургуулийн нийт багш нартаа “Төсөлт ажил” хичээлийн 3 зөвлөмжийг уншиж судлуулсан. • 2011-1 сард нийт багш нарынхаа дунд “Төсөлт ажил” хичээлийг хэрхэн заах тухай сургалт явуулсан.Тухайн сургалтаар багш нар нэлээд зүйлийг мэдэж, анги ангидаа тухайн хичээлийг орох сонирхолтой болж буй нь мэдрэгдэж байсан.

• 2011-3-р сард хичээлийн судалгаа хийх сарын аяны хүрээнд “Төсөлт ажил” судалгаат хичээлийг 2 удаа туршин явуулсан. • 8-4 ангид анги удирдсан багш Б.Болортол “Тамхи” сэдвээр 5 цагийн хичээл явуулсан. • 8-4 ангид гадаад хэлний багш В.Үржилцэцэг “Хог хаягдал” сэдвээр эцсийн тайлангаа судалгаат хичээл болгон явуулсан.	<u>Гарсан өөрчлөлт</u> • Хүүхдүүд хичээлд маш сонирхолтой оролцож байсан. • Хичээл ярьдаггүй хүүхэд ярьж байсан. • Хичээлд чин сэтгэлээсээ оролцож байсан. • Өөрийнхөө хийсэн зүйлээрээ бахархаж байсан. • Хичээл эрэлт хэрэгцээтэй байсан.
<u>Хүндрэл бэрхшээл:</u> • Хичээлийн ачаалал их байсан учир “Төсөлт ажил” –ыг нөгөө ээлжийн хичээлийн хуваарьт тусгахад анги танхим олдохгүй бэрхшээлтэй байлаа. • Материаллаг хэрэгсэл /цаас, пломастер, соронз, гэх мэт/ дутмаг байсан.	<u>Бэрхшээлийг шийдвэрлэсэн нь</u> • Дунд ангийн “Төсөлт ажил”-ын баг дахин багш нартаа сургалт явуулснаар анги ангидаа тухайн хичээлийг орох бүрэн боломжтой болсон. • Хичээлийн хуваарьт “Төсөлт ажил” хичээл, “Төсөлт ажил”-ын цаг гэсэн тусгай цагуудыг тусгаснаар багш нарт багаар хамтран ажиллах таатай боломжийг олгож байлаа.
• Б. Баясгалан багштай 8е анги “Соёлтой харилцаа”, Д.Энхсайхан багштай 7ё анги “Хог хаягдал”, Г.Байгальмаа багштай 8в анги “Юмнаар юм хийх” сэдвээр тус тус “Төсөлт ажил” –ыг явуулсан нь үр дүн сайтай байлаа. • Энэ нь “Төсөлт ажил” –ыг явуулах аргазүй түгэн дэлгэрч буйн бодитой жишээ юм. Ер нь манай сургуулийн бүх анги төсөлт ажлыг явуулж хэвшсэн.	• 2011 оны 4-р сард Б. Тунгалаг багштай 4ё ангид “Төсөлт ажил”-ыг туршин явууллаа. Бага ангийн баг тухайн хичээлд бүрэн сууж, хичээлийн хэлэлцүүлгийг тухай бүрт нь хийж байлаа. • 1-р цаг <u>сэдэв сонгох</u> Ангийн сурагчид 32 сэдвийг санал болгож, түүний дотроос “Гэрлэн дохио” сэдвийг сонгон судлагдахуунаа гарган багаа хуваарилсан. • 2,3-р цаг <u>мэдээлэлд боловсруулалт хийх</u> Сурагчид өөрсдийн цуглуулсан мэдээллээ авчран, засаж сайжруулж, завсрын тайландаа бэлтгэсэн.
• 4,5-р цаг <u>завсрын тайлан</u> Сурагчид мэдээллээ бусдадаа танилцуулж, харилцан ярилцсан. • 6,7-р цаг <u>эцсийн тайлан</u> Сурагчид бүх мэдээллээ нэгтгэн ханын сонин гарган тайлагналаа.	<u>Гарсан өөрчлөлт:</u> • Сэтгэл нь хангалуун байх болсон. • Бүгд “Би би” гээд л гараа өргөн суудал дээрээсээ өндөлзөн маш идэвхтэй оролцох болсон. • Хэл ярианы бэрхшээлтэй 3 сурагч өөрийн бэлтгэсэн материалаа ярьж чадсан нь хамгийн том ололт байлаа. • “Төсөлт ажил”-ыг дахин дахин орохыг шаардаж байв. • 4-ё анги сургуулийн ойролцоох замын гарцаар гарч хэвшсэн.

	<u>Хэлэлцүүлэгт оролцсон багш нарын санал сэтгэгдэл:</u> • МХУЗ-ын багш Б. Баярцэцэг:-Энэ хичээлийн ачаар сурагчид багаар ажиллаж сурсан.Би өөрийн мэргэжлийн хичээлээ “Төсөлт ажил” хичээлийн элемент аргазүйгээр явуулж хэвшсэн. • Гадаад хэлний багш Д.Энхсайхан:-Надад энэ хичээл үнэхээр их таалагдсан.Муу хүүхэд байдаггүй гэдгийг энэ хичээлийг орсноор мэдэрдээ. • Анхан шатны багш Б.Тунгалаг:-Манай ангийн сурагчид маш сайн хөгжиж байгаа.Ярьж чаддаггүй сурагч нэлээд олон байсан .Харин энэ хичээлийг орсноор тэдний ярих чадвар хөгжиж байгааг би харж байна.Улмаар ярих чадвар нь хөгжсөнөөр хичээлийн сурлагад нь тодорхой ахиц ажиглагдсан.
---	---

Эцэст нь дүгнэхэд багш дараах эрхэм чадваруудыг эзэмшин, бүтээлчээр хэрэглэвэл **төсөлт ажлаа үр дүнтэй явуулж чадахаас гадна цаашид хүүхэд өөрөө амьдралдаа тулгамдсан аливаа асуудлыг шийдвэрлэх чадварт сургадгийг** мэдрэх болно.

1	ХҮҮХЭД БҮРИЙН ХӨГЖЛИЙН насны онцлог, сурах арга барил харилцан адилгүй байдгийг ажиглан, тэмдэглэл хөтөлж, хүүхдийн хөгжлийн талаар цогц СУДАЛГАА ХИЙХ
2	ШИННИЙГ НЭЭЖ, ТАНИН МЭДЭХ ХҮСЭЛ ТӨРҮҮЛДЭГ СУРАЛЦАХ ОРЧИН, материал хэрэглэгдэхүүнийг БҮРДҮҮЛЭХ Ингэхдээ: ~ Хүүхэд бүр бусадтай чөлөөтэй харилцах, ~ Багш хүүхэд бүрт анхаарал хандуулах боломжтой эсэхийг бодолцох
3	Хүүхдийн төрөлхийн сониуч занд нь тулгуурлан, сургалтыг зохион байгуулахдаа ХАМТРАН СУРАЛЦАХУЙН БҮТЭЭЛЧ АРГА ЗҮЙГ ХЭРЭГЛЭХ
4	Багш судалгааны ажлын онол, арга зүйд суралцаж, ХҮҮХДИЙН хийж буй СУДАЛГААГ ЗӨВ ТИЙШ НЬ ЗАЛАХ, УДИРДАН ЧИГЛҮҮЛЭХ буюу: ~ Төлөвлөлт хийх, ~ Судалгаа хийх, мэдээлэл цуглуулах ~ Судалгааны материалд боловсруулалт хийх, цуглуулсан мэдээллээ эмхлэх, цэгцлэх, боловсруулах ~ Тайлагнах, илтгэх гэсэн төсөлт ажлын 4 үе шат бүрт бэлэн байж, суралцахуйг нь байнга дэмжих
5	ХҮҮХЭД БҮРТ ХИЙСЭН БҮТЭЭСЭНД НЬ УРАМ ИТГЭЛ ӨГЧ, бусадтай харилцах замаар сэтгэл зүйн болон танин мэдэхүйн чадварыг нь хөгжүүлэхдээ ӨӨРИЙГӨӨ ҮНЭЛЭХ, ӨӨРИЙН АЖЛЫГ БУСДЫНХТАЙ ХАРЬЦУУЛАХ, ӨӨРИЙГӨӨ ЗӨВ УДИРДАН ЧИГЛҮҮЛЭХ, ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛИЙГ БИЙ БОЛГОХ

ТӨСӨЛТ АЖИЛ багийн сургалтын хөтөлбөр

Ер №	өд өр	№	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУГАЦАА	СУРГАГЧ БАГШ
1	1	1	<u>Мөс хагалах мөч</u> “Манай багийнхны намтар”	9 ⁰⁰ - 9 ¹⁵	
2		2	<u>Ярилцлага-1</u> “Төсөлт ажлын талаарх миний ойлголт” “Төсөлт ажил манай сургууль дээр” /тандах судалгаа/	9 ¹⁵ - 9 ⁴⁵	
3		3	<u>Мэдээлэл -1</u> “ССДАЗХөгжил” төслийн хүрээнд Төсөлт ажил багийн хийсэн ажил • “Бид эхний шатны төслийн 3 жилд” • Төсөлт ажлын талаарх ерөнхий ойлголт	9 ⁴⁵ - 10 ³⁰	
4		4	<u>Дадлага-1. ОРОЛЦОГЧИД ӨӨРСДӨӨ СУРАГЧ БОЛНО.</u> • Төсөлт ажлын сэдэв сонгох	10 ³⁰ - 11 ⁰⁰	
5		5	<u>Мэдээлэл-2</u> Хэрэгжүүлж буй туршлага сургамж • Төсөлт ажлыг монголын нөхцөлд туршсан туршигч багш нарын туршилтын үеийн алдаа, оноо, түүнийг даван туулсан арга зам	11 ⁰⁰ - 11 ³⁰	
6		6	<u>Мэдээлэл-3</u> “Төсөлт ажилд сэдэв сонголт чухал болох нь” • Бага, суурь боловсролын төсөлт ажлын сэдэв сонголтын жишээн дээр	11 ⁴⁵ - 12 ⁰⁵	
7		7	<u>Дадлага-2</u> • Сонгосон сэдвээр сэдвийн тор үүсгэх • Сонирхлын бүлгээр судалгааны баг бүрдүүлэх • Дэд сэдвүүдээрээ судлагдахуунаа гаргах • Багийн төлөвлөлт хийх	12 ⁰⁵ - 13 ¹⁵ Үргэлжлэл 14 ¹⁵ - 15 ⁴⁵	
8	2	1	<u>Дадлага-3</u> • Төсөлт ажлын судалгаа хийх • Мэдээлэл цуглуулах • Судалгааны явцад тохиолдсон бэрхшээл, түүнийг хэрхэн даван туулсан тухайгаа ярилцах	9 ¹⁵ - 10 ⁰⁰	
9		2	<u>Мэдээлэл-4 Хичээлийн судалгаа</u> Төсөлт ажлын хичээлийн судалгаа /төсөлт ажлын бэлтгэл судалгаа, төсөлт ажлыг ажиглах, тэмдэглэл хөтлөх, хэлэлцүүлэг хийх онцлог	10 ⁰⁰ - 10 ³⁰	
10		3	<u>Дадлага-4</u> Цуглуулсан мэдээлэлдээ боловсруулалт хийх,	10 ³⁰ - 11 ³⁰	

		тайландаа бэлтгэх		
11		4 <u>Дадлага-5</u> /Оролцогчдоос тайлангийн цаг дээр ажиглалт хийх багш нарыг сонгох, ажиглалт хийлгэх, хичээлийн хэлэлцүүлэг хийх/ Баг тус бүр тайлан хамгаалах, хичээлийн хэлэлцүүлэг хийх	11 ³⁰ - 12 ³⁰	
12		5 <u>Хэлэлцүүлэг-1</u> Төсөлт ажлын тайланг хэрхэн хийж болох вэ? /Туршлага солилцох мөч/	14 ⁰⁰ - 15 ³⁰	
13		6 <u>Мэдээлэл-5</u> - Төсөлт ажлын тайлангийн хэлбэрүүд - Тус бүрийн онцлог	15 ³⁰ - 18 ³⁰	
14		1 <u>Хэлэлцүүлэг-2</u> Төсөлт ажлын үнэлгээг хэрхэн, яаж хийх вэ? Танд яг одоо юу бодогдож байна?	8 ⁴⁰ - 9 ⁰⁰	
15		2 <u>Мэдээлэл-6</u> Төсөлт ажлын үнэлгээний онцлог	9 ⁰⁰ - 9 ⁴⁰	
16		3 <u>Мэдээлэл-7</u> Төсөлт ажлын онцлог, уялдаа холбоо - Төсөлт ажил – интеграц хичээл, - төсөлт ажил- хамтын ажиллагаа - Төсөлт ажил ба тогтвортой хөгжлийн боловсрол - Төсөлт ажлын стандарт /Япон/, - Төсөлт ажлын хөтөлбөр, төлөвлөлт	9 ⁴⁰ - 12 ⁴⁰	
17	3	4 <u>Мэдээлэл-8</u> “Төсөлт ажлын арга зүй” кино үзүүлэх - Багийн сургалтаар олж авсан мэдээллээ бодит жишээн дээр харах, ажиглах - Төсөлт ажлын талаар нэгдмэл ойлголтоо бататгах	14 ⁰⁰ - 14 ⁵⁰	
18		5 <u>Хэлэлцүүлэг-3</u> Багийн нэгдсэн хэлэлцүүлэг - Багийн үндсэн оролцогчдоос судалгаа авах Багийн сургалтын хамгийн сайн хэсэг нь юу байв? Юу юуг шууд хэрэглэх боломжтой вэ? Цаашид юуг шинээр мэдмээр, судалмаар байна? - Чөлөөт ярилцлага /асуулт, хариулт/ - Дүгнэлт	14 ⁵⁰ - 16 ³⁰	

ТАЙЛБАР. Төсөлт ажил багийн 3 өдрийн сургалтаар төсөлт ажлын мөн чанарыг ойлгон, хичээлийн судалгаа /JK/ хийх ба ингэхдээ оролцогчид нь төсөлт ажлын үе шатуудыг өөрсдийн биеэр туулж, өөрөөр хэлбэл өөрсдөө сэдвээ сонгож, судлаад, тайлагнах /сурагч/, ажиглагч болох, хэлэлцүүлэг хийх /багш/, үйл ажиллагаанд оролцох юм. Ингэснээр төсөлт ажлын явцад тохиолддог саад бэрхшээл, алдаа оноог мэдэрч түүнийг хэрхэн даван туулах арга барилд суралцах болно.

Төсөлт ажлын судалгаат цаг дээр ажиглагчаар оролцсон багш нарын үнэлгээ өгөх хуудас

В2. Ажиглагчид хичээлд үнэлгээ хийх хуудас

Хичээлийн сэдэв:		Ажиглагчийн мэргэшил:	
Ажиглагчийн нэр:		Огноо:	
Албан тушаал: ажлын хэсэг, арга зүйч, захирал, сургалтын менежер, бусад ажиглагчид (äî î ãóð í ü çóðí à)		Анги, бүлэг:	

Энэ хичээлээр эзэмшүүлэх чадвар (Тухайн хичээлийн зорилт)	
---	--

Онооны утга (Хамаарах тоог дугуйлаарай) 3 : Õàí ãëòòàé 2 : Сайжруулах шаардлагатай, 1 : Хангалтгүй

Багц	Үзүүлэлт			Үнэлгээний бодит шалтгаан		
Сэдвээ сонгож, төлөвлөх, судлах чадвар	1	Хүүхэд, сонирхсон болон багшийн дэвшүүлсэн сэдвээс чөлөөтэй сонгох	3	2	1	
	2	Багшийн болон нөхдийнхөө санааг тусгаж төлөвлөх	3	2	1	
	3	Сонгосон сэдвээрээ судалгааны ажил явуулах	3	2	1	
Төлөвлөгөөг өө хэрэгжүүлэх болон бусадтай хамтран ажиллах чадвар	4	Бусдын яриаг анхааралтай хүлээцтэй сонсож, ойлгох	3	2	1	
	5	Өөрийн санаа бодлоо бусдадаа ойлгомжтой илэрхийлэх	3	2	1	
	6	Мэддэг зүйлээ бусдадаа зааж сургах	3	2	1	
	7	Судалгааны явцад янз бүрийн хүмүүстэй уулзаж, сонирхсон сэдвээр ярилцлага авах	3	2	1	
	8	Судалгааны явцад бусадтай хамтран ажиллах, нөхдөдөө туслах	3	2	1	
Мэдээлэлд боловсруулалт хийх чадвар буюу асуудлыг шийдвэрлэх чадвар	9	Мэдээллээ олон сувгаар цуглуулах	3	2	1	
	10	Олсон мэдээллээсээ хэрэгтэй зүйлээ сонгох	3	2	1	
	11	Сонгосон мэдээллээ эмхтгэж, боловсруулалт хийх, бусад хичээлээр олж авсан мэдлэгээ ашиглах	3	2	1	
Сурснаа хэрэглэх чадвар	12	Боловсруулсан мэдээллээ ашиглах, илтгэх, тайлагнах	3	2	1	
	13	Судалгааны явцад сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрэглэх	3	2	1	

ЛАВЛАГААНЫ МАТЕРИАЛ

1. Н.Нэргүй, Н.Оюунцэцэг нар, Стандартад суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах нь, УБ., 2007
2. Оюуны хөтөч, МУБИС-ийн боловсрол судлалын онол, арга зүйн эрдэм шинжилгээний бичиг, УБ., 2007
3. Ц.Наранцэцэг, Төсөлт ажил – Цуврал 1. УБ., 2006
4. Ц.Наранцэцэг, Б.Булган, Наканиши Рейко, Төсөлт ажлын аргазүй, Зөвлөмж – I, УБ., 2007
5. Ц.Наранцэцэг, Б.Булган, Ц.Оюун, Наканиши Рейко, Төсөлт ажлын аргазүй. Зөвлөмж – II, УБ., 2008
6. Ц.Наранцэцэг, Б.Булган, Ц.Оюун, Наканиши Рейко, Б.Гэрэл, Төсөлт ажлын аргазүй. Зөвлөмж – III, УБ., 2009
7. Розалин Мкеоун, Тогтвортой хөгжлийн төлөө боловсролд зориулсан багц материал, УБ., 2009
8. $\text{Ō} \text{ā} \text{ā} \text{ī} \text{ō} \text{ī} \text{é} \text{ō} \text{æ} \text{ē} \text{ē} \text{ī} \text{ō} \text{ē} \text{ō} \text{ō} \text{ā} \text{ī} \text{ē} \text{ī} \text{ā} \text{ñ} \text{ō} \text{ī} \text{ē}, \text{᠓} \text{ī} \text{ā} \text{y} \text{ñ} \text{ī} \text{ē} \text{ē} \text{ç} \text{°} \text{ā} \text{ē} \text{°} \text{ā} \text{°} \text{ī} \text{ē} \text{ē} \text{y} \text{ī} \text{ō} \text{ō} \text{ā} \text{y} \text{ē}, \text{Ó} \text{Á} \text{.}, 2007.04.06.$
9. Н.Нэргүй, Б.Бурмаа нар, Тогтвортой хөгжлийн боловсрол, УБ., 2008
10. Б.Бурмаа, Н.Оюунцэцэг нар. Багш нарт зориулсан сургалтын гарын авлага: Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ., 2008
11. Японы ЕБС-ийн төсөлт ажлын стандарт, 2011
12. Х.Батхүү, Б.Булган, Сургалтын явцад хүүхдийг идэвхжүүлэх бүтээлч аргууд, УБ., 2010
13. Ц.Наранцэцэг, “Төсөлт ажлын аргазүй” бага, суурь DVD, 2009
14. <http://www.google.com./tusultajil/>
15. БСШУЯам болон ЖАЙКА-ийн хамтарсан төслийн I, II шатны “Төсөлт ажил” багийн туршигч багш нарын тайлангууд, 2006-2013